

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2026 оны 05 дугаар сарын 05-ны өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-28
<hr/>	
1.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 18 дугаар тогтоолоор байгуулагдсан Хог хаягдлын тухай хулийн хэрэгжилтийг хянан шалгах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт	4-27
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/	28

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
05 дугаар сарын 05-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 29 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 51.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 18 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Бат-Эрдэнэ, С.Ганбаатар, М.Мандхай;
Чөлөөтэй: Д.Амарбаясгалан, С.Амарсайхан, Д.Батбаяр, Б.Батцэцэг, Х.Ганхуяг, Д.Жаргалсайхан, Ц.Мөнхбат, Ц.Туваан, Ж.Чинбүрэн.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Б.Бейсен хариулж, тайлбар хийв.

Нэг.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 18 дугаар тогтоолоор байгуулагдсан Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хог хаягдал, орчны бохирдлын хэлтсийн дарга Ц.Очироо, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн Хот, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан зөвлөх Ө.Ганболд, хог хаягдлын менежментийн зөвлөх Б.Дэлгэрбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл, Хяналт шалгалтын газрын ахлах зөвлөх Х.Энэбиш нар байлцав.

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 18 дугаар тогтоолоор байгуулагдсан Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Ганбаатар, П.Батчимэг, Б.Бат-Эрдэнэ, С.Замира, Н.Алтаншагай, Б.Бейсен нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батбаяр, мөн яамны Хүрээлэн буй орчны бодлогын

хэрэгжилтийн газрын дарга Г.Энхмөнх, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, хог хаягдлын менежментийн зөвлөх Б.Дэлгэрбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Замира, Б.Бат-Эрдэнэ, С.Одонтуяа, Б.Бейсен нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 18 дугаар тогтоолоор байгуулагдсан Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцав.

Уг асуудлыг 16 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл хэлэлцэх асуудлын дарааллын 2 дугаарт орсон “Хог хаягдлын эрх зүйн орчныг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцүүлгийг долоо хоногоор хойшлуулах санал гаргаж, уг асуудлыг хойшлуулав.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, зөвлөх П.Хулан, референт Б.Бадралт, Ц.Рэнцэнтогтох, Б.Энхгэрэл нар байлцав.

Байнгын хорооны дарга Б.Бейсен “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Бейсен: “Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 05 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 6

Бүгд: 17

64.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 27 минут үргэлжилж, ирвэл зохих 29 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 58.6 хувийн ирцтэйгээр 16 цаг 45 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Б.БЕЙСЕН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 05 дугаар сарын 05-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
15 цаг 18 минут.

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдэд энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 51,7 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн /БОХХАА/-н байнгын хорооны 26 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр танилцуулъя. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн ирсэн байна, Буланы Бейсен гишүүн ирсэн байна, Сонгобайн Замира гишүүн ирсэн байна, Тогтмолын Мөнхсайхан гишүүн ирсэн байна, Ренчинбямбын Сэддорж гишүүн ирсэн байна, Очирбатын Амгаланбаатар гишүүн ирсэн байна, Гомбын Ганбаатар гишүүн ирсэн байна, Сүрэнжавын Лүндэг гишүүн ирсэн байна, Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна, Агваанлувсангийн Ундраа гишүүн ирсэн байна, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Мөнгөнцогийн Ганхүлэг гишүүн ирсэн байна, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн ирсэн байна, Ухнаагийн Отгонбаяр гишүүн ирсэн байна, Болдын Уянга гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 3 асуудал хэлэлцэнэ. 1 дүгээрт, БОХХАА-н байнгын хорооны 2025 оны 18 дугаар тогтоолоор байгуулагдсан Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох. 2-т Улсын Их Хурлын тогтоолын төсөл Хог хаягдлын эрх зүйн орчныг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай. 3-д Байнгын хорооны тогтоолын төсөл Цаглавар батлах тухай. Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу? Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Ардчилсан нам /АН/-ынхан бусад асуудлаар завсарлага авсан, тэр юу болсон юм бол, тэрийг тодруулж өгөөч?

Б.Бейсен: Өнгөрсөн Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар энэ асуудлыг ярьсан. Байнгын хорооны даргын асуудал би ч өгөхөд бэлэн байгаа. Гэтэл тэн дээр АН-аас асуудал тавьсан байна. Тэгээд Их Хурлын дарга, Бүлгийн дарга танилцуулсан, Бүлгийн дарга хуулиараа байгаа гэсэн. Их Хурлын дарга 2 бүлгийн дарга хэлэлц гэсэн, тэрний бичиг явж байх шиг байна. Тэгээд энэ асуудал энэ удаад ороогүй, хойшлогдсон байна. Хэлэлцэх асуудалд орёе.

Нэг.Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2025 оны 18 дугаар тогтоолоор байгуулагдсан Хог хаягдлын тухай хуулийн

хэрэгжилтийг хянан шалгах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

БОХХАА-н байнгын хорооны 2025 оны 18 дугаар тогтоолоор байгуулагдсан Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг сонсох. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын хэсэг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /НЗДТГ/ Ө.Ганболд Нийслэлийн Засаг дарга /НЗД/-ын Хот, нийтийн аж ахуйн асуудал хариуцсан зөвлөх, М.Үнэнбат Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга, Ц.Очироо Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /УБЗАА/-ны Хог хаягдал, орчны бохирдлын хэлтсийн дарга, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Ц.Батбаяр Төрийн нарийн бичгийн дарга /ТНБД/-ын албан үүрэг түр орлон гүйцэтгэгч, Г.Энхмөнх Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын дарга, Б.Дэлгэрбаяр Хог хаягдлын менежментийн зөвлөх.

БОХХАА-н байнгын хорооны 2025 оны 18 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлт гаргасан байна. Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл танилцуулна. Мөнхсоёл гишүүнд микрофон өгье. Ирцэд орсон юм уу Мөнхсоёл гишүүн? Мөнхсоёл гишүүний микрофон өгье.

Б.Мөнхсоёл: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурал /УИХ/ БОХХАА Байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 18 дугаар тогтоолоор Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл миний бие, бүрэлдэхүүнд нь Улсын Их Хурлын гишүүн Н.Алтаншагай, С.Ганбаатар, С.Замира, Ж.Золжаргал, Т.Мөнхсайхан, С.Одонтуяа, А.Ундраа, Б.Уянга ажиллалаа. Мөн тус ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах чиглэлээр Улсын Их Хурлын Тамгын газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Эрүүл мэндийн яам /ЭМЯ/, НЗДТГ, хог хаягдлын салбарын төрийн бус байгууллагууд, дахин боловсруулах үйлдвэрүүд, мэргэжлийн холбоод, хог хаягдлын менежментийн зөвлөхүүдийг татан оролцуулсан.

Ажлын хэсэг салбарын яам, орон нутгийн хог хаягдлын асуудал хариуцсан газар, хэлтэс, хог хаягдлын менежментэд оролцогч байгууллагууд, төрийн бус болон холбоод, дахин боловсруулах үйлдвэрийн төлөөллүүдтэй 5 удаагийн хуралдаан, 2 уулзалт, 4 хэлэлцүүлэг зохион байгуулж, түүнчлэн Налайх дүүргийн үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа болон ЗДТГ-аас хог хаягдлын менежментийн талаар хэрэгжүүлж байгаа ажилтай газар дээр нь очиж танилцсан. Хог хаягдлын хууль тогтоомжийн хэрэгжилт, өнөөгийн нөхцөл байдал, менежментэд тулгамдаж байгаа асуудал, шийдвэрлэх боломжийн талаар зохион байгуулсан 4 удаагийн хэлэлцүүлэгт нийт 43 байгууллагын төлөөлөл, 400 гаруй бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгж /ААН/, аймаг, нийслэл, сум, дүүргийн холбогдох мэргэжилтнүүд, төрийн болон төрийн бус байгууллагууд оролцож, хог хаягдлын менежменттэй холбоотой нийт 175 санал гаргасныг хүлээн авч, саналыг нэгтгэн боловсруулсан.

Түүнчлэн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Сангийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Зам, тээврийн яам, Батлан хамгаалахын яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар /ЗГХЭГ/, НЗДТГ, 21 аймгийн Засаг дарга нараас Хог хаягдлын хуулийн хэрэгжилт болон хог хаягдлын талаар хийж хэрэгжүүлсэн ажил болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг албан бичгээр авсан. Дани улсын Социал демократ нам, Социалист ардын намуудын хамтарсан Ногоон хог хаягдлын менежментийн төслийн хүрээнд Дани улсын хог хаягдлын менежментийн шилдэг туршлагатай танилцах аяллыг Их Хуралд суудалтай 5 намын төлөөллийг оролцуулан зохион байгуулж, Дани Улс болон Европын Холбооны сайн туршлагыг судлан энэхүү санал, дүгнэлтэд тусгасан болно.

Дээр дурдсан хэлэлцүүлгүүдээс гарсан санал, төрийн болон төрийн бус байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэл, олон улсын хог хаягдлын менежментийн талаарх туршлага, шинэ санаа, бодлогын зөвлөмжийг нэгтгэн боловсруулж, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэгт тус тус заасны дагуу бэлтгэн ажлын хэсгээс дараах танилцуулга, санал, дүгнэлтийг бэлтгэн та бүхэнд танилцуулж байна.

Сүүлийн жилүүдэд хүн амын өсөлт, хотжилт, үйлдвэржилтийн нөлөөгөөр хог хаягдлын менежмент Монгол Улсын хувьд тулгамдсан асуудлуудын нэг болоод байна. 2024 оны байдлаар Монгол Улсад 2,7 сая тонн хог хаягдал үүсэж байгаа нь 5 жилийн өмнөх үзүүлэлттэй харьцуулахад 35 хувиар өссөн байна. Хог хаягдлын үүсэлт, хэмжээг бодитой үнэн зөв бүртгэх тогтолцоо аймаг, сумуудад хангалтгүй байгаа бөгөөд улсын хэмжээнд үүсэж байгаа хог хаягдлын хэмжээ өнөөгийн бүртгэлээс илүү байх магадлалтай юм. 2024 онд Улаанбаатар хотод үүсэж байгаа дахин боловсруулах боломжтой хог хаягдлын 12 хувийг орон нутагт үүсэж байгаа дахин боловсруулах боломжтой хог хаягдлын 1,25 хувийг цуглуулж, тээвэрлэн дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлсэн байна.

Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд хог хаягдлын дахин боловсруулалтын хувь хэмжээнд тодорхой өсөлт ажиглагдахгүй байна. Монгол Улсын хэмжээнд 3511,8 га талбайг хамарсан 396 хогийн цэгт хог хаягдал ил задгай байдлаар булшлагдаж байгаа бөгөөд нийт хог хаягдлын төвлөрсөн цэгийн зөвхөн 2 хувь нь байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангаж байна. Үлдсэн хог хаягдлын төвлөрсөн цэгүүдэд хог хаягдал ил задгай хаягдаж, хуурайшилтын үед шатах, бороо үерийн усаар урсах, салхиар тархах зэргээр агаар, хөрс, усны бохирдолд гол нөлөө үзүүлж байна. Жил бүр хог хаягдал булшлах төвлөрсөн хогийн цэгийн талбай улсын хэмжээнд нэмэгдэж байгаа бөгөөд зөвхөн Улаанбаатар хотын 3 хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбай сүүлийн 10 жилд 3-аас 5 дахин нэмэгдсэн байна.

2017 оны Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд холбогдох журмуудыг батлан хэрэгжүүлж байгаа боловч хог хаягдлын менежментийн тогтолцоо тархмал, орон нутгийн түвшинд зохицуулалт сул, санхүүжилт хангалтгүй, хувийн хэвшлийн оролцоо хязгаарлагдмал, үйлчилгээний чанар, хүртээмж сайжрахгүй хэвээр байгаа юм.

Дүгнэлт Хог хаягдлын менежментийн өнөөгийн нөхцөл байдал, салбарын оролцогч талуудын санал хэлэлцүүлгийн үр дүнд үндэслэн дараах нэгдсэн дүгнэлтийг хийж байна. Монгол Улсын хог хаягдлын менежмент, санхүүжилтийн

тогтолцоо нь зөвхөн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлахад төвлөрсөн санхүүжилт хангалтгүй, хүний нөөц тогтворгүй, хариуцлагын механизм сул байгаа нь салбарын хөгжлийг хязгаарлаж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг нэмэгдүүлж байна. Иймд тус салбарт эрх зүй, санхүү, институт, зах зээлийн цогц шинэчлэл хийх шаардлага зайлшгүй тулгарч байна. Нэн тэргүүнд хог хаягдлын санхүүжилтийн тогтолцоог шинэчилж, үүсгэсэн хэмжээгээр төлөх зарчимд суурилсан төлбөрийн механизмыг бүрдүүлэх, ААНБ-ын хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүрэг тогтоодог эрх зүйн орчныг өөрчлөн чөлөөт үнийн тогтолцоонд шилжүүлэх нь зүйтэй байна. Ингэснээр үйлчилгээний чанар, үр ашиг дээшилж, хог хаягдал бууруулах эдийн засгийн хөшүүрэг бодитоор бий болно.

Мөн хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлтийн салбарт өрсөлдөөнийг нэвтрүүлж, ААН-үүд тээвэрлэгч байгууллагаа өөрсдөө сонгон гэрээ байгуулах боломжийг бүрдүүлэх нь үйлчилгээний чанар, хариуцлагыг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Үүний зэрэгцээ эх үүсвэр дээр ангилан ялгасан хог хаягдлыг тусгайлан цуглуулах, тээвэрлэх тогтолцоог бий болгох хэрэгцээ байна. Үйлдвэрлэгч импортлогчийн өргөтгөсөн хариуцлагын тогтолцоог бүрэн хэрэгжүүлж, ялангуяа цахим цахилгаан хэрэгсэл, сав баглаа боодол зэрэг бүтээгдэхүүний хаягдлыг эргүүлэн татах, дахин боловсруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байна. Үүнтэй уялдуулан депозит систем, урамшууллын механизмыг нэвтрүүлэх нь чухал юм.

Орон нутгийн түвшинд хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийн менежмент сул, хэмжилт, бүртгэлийн тогтолцоо хангалтгүй байгаа тул авто хэмжилтийн техник, хэрэгслээр бүрэн хангаж, нэгдсэн бүртгэл, мэдээллийн системд холбох шаардлагатай байна. Мөн төвлөрсөн цэгүүдийн байршил, хүчин чадал, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн иж бүрэн судалгаанд үндэслэн шинэчлэх, нөхөн сэргээх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх нь зүйтэй. Барилга нураалтын хог хаягдлын хувьд үнэ тарифын тогтолцоог шинэчилж, ангилал, стандарт журам, хор аюулын зэрэглэлийг тодорхой болгох, цуглуулах, тээвэрлэх, боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн оролцоонд тулгуурлан хөгжүүлэх, дахин боловсруулах дэд бүтцийг бий болгох шаардлагатай байна.

Аюултай хог хаягдлын чиглэлээр улсын хэмжээнд тооллого хийж, нэгдсэн бүртгэл бий болгох, ангилал, жагсаалтыг шинэчлэх, устгалын дэд бүтэц байгуулах тусгай зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгож, цахимжуулах шаардлагатай байна. Мөн малын гаралтай хог хаягдлын асуудлыг тусгайлан авч үзэж, бүтэц хэмжээний судалгаанд үндэслэн цуглуулалт, тээвэрлэлт, дахин боловсруулалтын бие даасан тогтолцоог бүрдүүлэх, мал нядалгааны болон мах боловсруулах үйлдвэрүүдийн хариуцлагыг тодорхой болгох нь зүйтэй.

Дахин боловсруулах салбарыг хөгжүүлэх хүрээнд дахивар түүхий эдийг дахин боловсруулж, хийсэн бүтээгдэхүүнийг төрийн худалдан авалтаар дэмжих, дахин боловсруулсан бүтээгдэхүүнд урамшуулал олгох, татварын хөнгөлөлт үзүүлэх, тухайлбал нэмэгдсэн өртгийн албан татварын зохицуулалт, ногоон зээлд хамрагдахад төрөөс баталгаа гаргах зэрэг бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Мөн дахивар түүхий эдийн цуглуулалт, тээвэрлэлтийн санхүүжилтийг шийдвэрлэх нь чухал юм. Цаашид салбарын бодлого зохицуулалт олон салбарт хуваагдсан байдлыг халж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын бүтэц байгуулах замаар бодлогын уялдаа, хэрэгжилтийн үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.

Үүний зэрэгцээ орон нутгийн эрх мэдэл, үүргийг тодорхой болгож, хог хаягдлын менежментийн хэрэгжилтийг нийслэл, аймаг, дүүрэг, сумын онцлогт нийцүүлэн зохион байгуулах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй. Мөн хог хаягдлын менежментийн бүх шатад тухайлбал ангилал, цуглуулалт, тээвэрлэлт, дахин боловсруулалт, устгал зэрэгт нэгдсэн стандарт, шаардлагыг мөрдүүлэх, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, олон нийтийн хандлага, боловсролыг дээшлүүлэх сургалт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Хог хаягдлын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эрх зүйн орчныг сайжруулж, бодлогын зорилтуудыг хэрэгжүүлснээр хог хаягдлын салбар илүү тогтвортой, үр ашигтай, ил тод болно. Энэхүү цогц арга хэмжээний саналуудыг үе шаттай хэрэгжүүлснээр Нийслэл, хот, орон.../минут дуусав/

Б.Бейсен: Мөнхсоёл гишүүний микрофон өгье.

Б.Мөнхсоёл: Хэмжээнд тулгамдаж буй, энэхүү цогц арга хэмжээний саналуудыг үе шаттай хэрэгжүүлснээр нийслэл, хот, орон нутгийн хэмжээнд тулгамдаж буй асуудал, сорилтуудыг эрх зүй, бодлогын түвшинд шийдвэрлэн, хог хаягдлын менежментэд оролцогч талуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлэн, хог хаягдал үүсгэж байгаа хэмжээгээр төлөх төлбөрийн шударга системд шилжиж, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах, ангилан ялгах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйлдвэрүүдийг татвар, урамшууллын бодлогоор дэмжин, үйлдвэрлэгч, импортлогчийн өргөтгөсөн хариуцлагын тогтолцоог бүрдүүлж чадна гэж үзэж байна. Ингэснээр Монгол Улс хог хаягдлын салбарт тогтвортой санхүүжилтийн тогтолцоотой болох, хариуцлагад суурилсан зах зээлийн механизм бүрдэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйлдвэрлэл хөгжих, байгаль, орчны бохирдол буурах, ногоон эдийн засгийн шинэ салбарууд бий болох нөхцөл бүрдэж, хог булшлах асуудлаас нөөц болгон ашиглах тогтолцоонд шилжих стратегийн суурь тавигдана гэж үзэж байна.

Иймд Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн танилцуулга, санал, дүгнэлт болон хог хаягдлын менежментийн санхүүгийн тогтолцоог шинэчлэх, хог хаягдлыг эх үүсвэр дээр багасгах, ангилан ялгах, дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжих эрх зүйн орчийг бий болгох зорилгоор Улсын Их Хурлын тогтоолын боловсруулсан төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Бейсен: Мөнхсоёл гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу нэрсээ өгнө үү? Ганбаатар гишүүнээр тасаллаа. Г.Ганбаатар гишүүн асуулт асууя ирцээрээ.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд. Энэ Байнгын хорооноос байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцлаа л даа. Тэгээд яах вэ энэ хүн амын өсөлт, энэ хотжилт, энэ үйлдвэржилтийн нөлөөгөөр сүүлийн 5 жилийн дотор энэ хог хаягдлын, хог хаягдал 35 хувиар нэмэгдсэн 2,7 сая тонн болсон гэж байна. Ер нь тэгэхдээ энэ цаашдаа энийгээ хог хаягдлынхаа менежмент, дээрээс нь энэ эрх зүйн орчныг нь яаралтай сайжруулахгүй бол энэ чинь ийм хурдацтай өсөж байгаа юм байна шүү дээ 35 хувиар өснө гэж байна. Тэгэхлээр хот дээр тэр нь санал, дүгнэлт дотор энэ

нөгөө бохирдуулагч үүсгэсэн хэмжээгээрээ төлөх зарчим бодит байдал дээр хэрэгжихгүй байна гэж. Тэгээд ажлын хэсгээс болоод энэ холбогдох орж ирсэн хүмүүсээс асуухад энэ яагаад уг нь хамгийн зөв зарчим шүү дээ. Хэн их бохирдуулсан нь төлөх ёстой, тэр хэмжээгээр төлөх ёстой, яагаад хэрэгжихгүй байгаа юм бэ? Хууль, эрх зүйн орчиндоо байгаа юм уу, эсвэл хог хаягдлынхаа менежменттэй байгаа юм уу, эсвэл тэр нь өөрөө нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд нь холбогдох шийдвэр, төлбөр, юмнуудаа гаргахгүй байгаа юм уу, юунаасаа болоод хэрэгжихгүй байгаа юм бэ гэдэг нэг асуулт байна?

2 дугаарт нь Багахангайд нэг энэ дугуйны үйлдвэр дахин боловсруулаад, Багахангай орчимд гэсэн байх, дахин боловсруулаад тэгээд сүүлдээ тэрнээсээ ийм дизель түлш эд нэрэх үйлдвэр байгуулагдаж байгаа сураг гарсан. Иймэрхүү дахиврыг дахин ашиглах, энэ аккумулятор энэ ашигласан дугуй, ашигласан аккумулятор, ашигласан дугуй эд нарыг дахин ашиглаж байгаа үйлдвэрүүд дээр ямар энэ төрөөс бодлогын дэмжлэг үзүүлдэг юм бэ, үүнийг нэг тодорхой хариулт өгөөч? Энэ 2 асуултад.

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч Мөнхсоёл гишүүн, дараа нь мэргэжлийн байгууллагууд хариулъя.

Б.Мөнхсоёл: Би эхлүүлээд, манай мэргэжлийн байгууллагууд давхар хариулт өгөх байх. Би зүгээр эхний асуулт дээр яагаад ажилладаггүй вэ гэхээр тийм хуулийн хэрэгжилт сул байгаа, түүн дээр олон шалтгаан байгаагийн нэг нь тарифын нөгөө чөлөөлөлт байхгүй. 2 дугаарт ААН-үүд өөрсдөө хог цуглуулдаг, тээвэрлэдэг компани сонгох боломж байхгүй зэрэг шалтгаанууд үндсэн шалтгаанууд байгаа. Тэгээд Дэлгэрбаяр зөвлөх нэмээд хариулчих.

Б.Бейсен: 4 номерын микрофон хариулъя, албан тушаалаа хэлээрэй.

Б.Дэлгэрбаяр: Би Дэлгэрбаяр хог хаягдлын менежментийн зөвлөх. Тэгэхээр Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд хог хаягдлын төлбөр маань өөрөө сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал /ИТХ/ тогтоож байгаа. Сум, дүүргийн ИТХ буюу нийслэл дээр 9 дүүрэг, 360 гаран сум өөр, өөр тарифтай ингэж явдаг. Энэ маань өөрөө Иргэдийн хурал тогтоодог учраас зөвхөн нийслэлийн дүүрэг дээр аваад үзвэл 60 гаран төрлийн хог хаягдлын тариф тогтоож байна. Жижиг Түц ч гэдэг юм уу, гуталчин, үсчин гэх мэтээр. Ингээд төрөөс тогтоочхож байгаа болохоор яг хог хаягдал гаргасан хэмжээгээрээ төлөх энэ боломжгүй. Жишээ нь том хэмжээний үйлдвэр гэхэд гаргасан хэмжээгээрээ биш, Иргэдийн хурлаар тогтоосон тэр 200 мянган төгрөг ч гэдэг юм уу энийг тогтоочихдог. Яг үнэн хэрэгтээ нийслэл хогийг нь тээвэрлэхэд 200 биш, бараг сард сая.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Б.Дэлгэрбаяр: Сая, 1 сая 500 мянган төгрөг гаргадаг энүүгээрээ төслийн алдагдалд орж байгаа. Тийм учраас энэ эрх зүйн орчны өөрчлөлтийн хүрээнд хог хаягдлын үнийг чөлөөлж, чөлөөт үнийн системд буюу тээвэрлэгч байгууллага, үүсгэж байгаа байгууллага хоорондоо үнээ зохицдог, үнэ төлбөрөө шийддэг ийм чөлөөт үнийн системд оруулъя, энийг эрх зүйн хувьд нь одоо нээж өгөөч гэж энэ тогтоолын төсөлд тусгасан байгаа.

Б.Бейсен: 5 номер, аюултай хог хаягдлын асуулт асуусан байна Ганбаатар гишүүн. 1 номер.

Г.Энхмөнх: Гишүүний асуултад хариулъя. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам Хүрээлэн буй орчны бодлогын газрын дарга Энхмөнх. Орон нутагт Хог хаягдлын тухай хууль хэрэгжихгүй байгаатай холбоотой хэд хэдэн тоо баримтуудыг хэлье. Аймгийн түвшинд гэхэд энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, устгах, булшлах гээд журам байж байгаа. Хууль 2017 онд гарсан. Гэтэл өнөөдрийн байдлаар энэ журмаа баталсан 13 аймаг байна, журмаа огт батлаагүй 9 аймаг байна гэсэн ийм статистик байж байгаа. Сумын түвшинд аваад үзэхэд энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх нэгж тарифаа тогтоосон, мөн хог хаягдлын үйлчилгээний хураамжаа тогтоосон нийт сумдаас тогтоосон нь 216, огт батлаагүй нь 114 сум байна гэсэн тоо статистик байж байгаа. Ингээд эндээс харахад үндсэндээ тухайн орон нутгийн өөрөө удирдах байгууллагад маань энэ цуглуулах, тээвэрлэх зардлын тариф болоод энэ.../минут дуусав/

Б.Бейсен: 1 номер гүйцээж хариулъя.

Г.Энхмөнх: Хураамжаа бүрэн тогтоогоогүй байдаг юм байна лээ. Үүнээс уялдуулаад хог хаягдлын хураамж бүрэн төвлөрдөггүй, буцаагаад хог хаягдлын менежментэд бүрэн зарцуулахад хүндрэл үүсдэг ийм асуудал байж байгаа. 2 дугаарт нь тэр үйлдвэрлэгчдийн өргөтгөсөн хариуцлагатай холбоотой асуудал дээр энэ дээр зөвхөн Сангийн сайд болоод Байгаль орчны сайдын 2018 оны хамтарсан журам байгаад байгаа юм. Тэгээд журмаар 11 нэр төрлийн бүтээгдэхүүнийг буцаагаад төвлөрүүлэх, импортлох, экспортлоход тариф тогтооно, буцаан цуглуулах гэсэн ийм зохицуулалт байж байгаа. Гэтэл яг хуулиараа энэ нарийн зохицуулагдаагүйгээс болоод энэ үйлдвэрлэгчдийн өргөтгөсөн хариуцлагатай холбоотой асуудал огт хэрэгжихгүй ийм нөхцөл байдалтай байгаа. Одоо бид хэд Хог хаягдлын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр энэ тойрог эдийн засаг болоод, үйлдвэрлэгчдийн өргөтгөсөн хариуцлагатай холбоотой асуудлыг бүрэн хэмжээнд тусгаад оруулж ирж байгаа юм.

Б.Бейсен: Гомбын Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Миний асуултад жоохон дутуу хариулчихлаа. 1 дүгээрт нь би тэр дахивар, ялангуяа энэ ашигласан аккумулятор, тэр энэ маш их уул уурхайгаас болоод энэ манай улс машин тэрэг их болчихсон юм, маш их хэмжээний ашигласан дугуйнууд гарч байна энэ чиглэлийн үйлдвэрүүд бий болчихоод байна. Тэгээд энийг урамшуулах, төрөөс дэмжих ямар бодлого байгаа юм бэ гэж асуусан асуултдаа хариулт авсангүй.

2 дугаарт нь тэр нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд, аймгууд, зарим аймгууд, 114 сум нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь буюу иргэдийн хурал нь тэр журмаа гаргахгүй л байгаа юм байна. Байгаль орчны яамнаас энэ чиглэлээр зөвлөмж хүргүүлээд тэгээд яах вэ нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага өөрөө нутаг дээрээ засаглах тийм статустай л даа хуулиараа. Гэхдээ зөвлөмж хүргүүлээд нэг жоохон шахаад, энэ хог хаягдлынхаа менежмент дээр, эрх зүйн орчин дээр нь анхаараад байж болдоггүй юм уу? Энд ярих өөр, та нар тэр.../минут дуусав/

Б.Бейсен: 1 номер Энхмөнх дарга хариулъя.

Г.Энхмөнх: Энэ орон нутгийн чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд жил болгон Байгаль орчны сайд болоод аймгийн Засаг дарга нар хоорондоо хамтарсан гэрээ байгуулж байгаа юм. Энэ дээр хуулиар эрх олгогдсон журмуудыг батлах, хэрэгжилтийг хангах энийг жил болгон үүрэгжүүлээд явж байгаа. Нөгөө талаасаа Байгаль орчны яам 2024, 2025 онуудад тухайн орон нутагтаа хог хаягдал ангилах, цуглуулах төв, тухайн сумд байгаа хог хаягдлын төвийн жишиг зургуудыг батлаад, мөн орон нутагт хүргүүлсэн. Ингээд жишиг зургаараа хог хаягдал ангилан ялгах төвүүд болоод хог хаягдлын цэгүүдээ байгуулаад ингээд тарифаа тогтоогоод явах бүрэн боломж бололцоо байгаа. Байгаль орчны яамнаас харин бүсчилсэн байдлаар аюултай хог хаягдлыг түр хадгалах агуулахуудыг бариад явж байгаа. Одоогоор бэлэн болчихсон 5 агуулах, 70-аас 8 хувийн гүйцэтгэлтэй 10 агуулах байж байна. Цаашдаа.../минут дуусав/

Б.Бейсен: 1 номер гүйцээж хариулъя.

Г.Энхмөнх. Аюултай хог хаягдлын түр хадгалах баригдаагүй байгаа Сүхбаатар, Өмнөговь, Увс, Баян-Өлгий, Ховд аймгуудад бид аюултай хог хаягдлын түр хадгалах агуулахыг барихаар төлөвлөөд байж байгаа.

Б.Бейсен: Мөнхсоёл гишүүн гүйцээж хариулъя. Дараа нь 5 номер хариулъя.

Б.Мөнхсоёл: Ер нь яг энэ манай Ганбаатар гишүүний асуусан асуулт зөв л дөө. Яг энэ асуудлууд байгаа учраас Байнгын хорооноос ийм хог хаягдлын асуудлаар хяналт шалгалт хийх ийм ажлын хэсэг гарсан шүү дээ. Одоо тэгээд бидний олон удаа хэлэлцүүлгээр нийслэл дээр ч асуудлууд байна, орон нутагт ч байна, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд ч байна. Тэгэхээр энэ бие биедээ найдсан, хяналтгүй, гүйцэтгэл муу энэ байдлыг халахын тулд энэ тогтоол гарах гэж байгаа шүү. ЗГ-т чиглэл өгөх гэж байгаа тэрэн дотор 12 салбар асуудал байгаа. Энэ Ганбаатар гишүүний хөндсөн асуудал ч орж байгаа. Одоо эзэнтэй болохгүй бол бие биедээ найдаад өнгөрөөдөг ийм асуудлыг цэгцлэх ёстой юм байна лээ.

Б.Бейсен: 5 номер гүйцээж яриулъя. 5 номерын микрофон. Ажиллаж байгаа юм уу наадах чинь, ажиллахгүй байгаа юм уу? 5 номерын микрофон, ажиллахгүй байгаа юм байна даа, 6 руу очоод, 6 номерын микрофон өгье. Микрофон нь болохгүй байгаа юм уу? 4 номер ажиллах нь уу аль эсвэл 4. 4 номерын микрофон.

М.Үнэнбат: Ганбаатар гишүүний асуултад нэмэлт хариулт өгье. НЗДТГ Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газар. Ганбаатар гишүүн их чухал асуулт хөндлөө. Яагаад гэхээр энэ хогийг сэргээн ашиглах, энэ дахиврыг дахиад бүтээгдэхүүн бий болгож байгаа энэ асуудал дээр урамшууллын асуудлууд ер нь энэ ААН-ийг дэмжиж байгаа асуудал яг өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулийн зохицуулалт бол байхгүй байгаад байгаа. Тэгэхээр одоо бид бүхэн нийслэлийн зүгээс өнгөрсөн хугацаанд нэг жил гаруйн хугацаанд төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудлаар энэ хогийг дахин боловсруулах, хогийг сэргээн ашиглах чиглэлээр энэ хог шатааж, эрчим хүч гаргах үйлдвэрийн төслийг хувийн хэвшлийн санаачилгад тулгуурлаад ингээд зохион байгуулаад явж байгаа. Өнөө өдөр 2 ААН ороод ирчихсэн байна. Ингээд хог, өдөрт нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 2,8 тонн орчим хог гарч байгаа. Энэний 1,5 тонн орчмыг шатааж эрчим хүч гаргах ийм боломж нь ТЭЗҮ-ээр батлагдчихсан ийм төсөл байж байгаа. Энэ төсөл явж байгаа.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулья.

М.Үнэнбат: Тэгээд эрчим хүч гаргаад, тухайн эрчим хүчийг төвийн шугамд нийлүүлж байгаа үнэ нь нэг өөр. Тэрийг Эрчим хүчний зохицуулах хорооноос батлуулаад ингээд явчихдаг. Тэгэхээр энэ хог шатааж байгаа үйлдвэр нь өөрөө эргээд энэ байгаль орчинд ээлтэй аргаар энэ хогийг боловсруулж байгаа учраас энийг дэмжлэг байдаггүй учраас энэ хоорондын яг үйлдвэрлэж байгаа үнэ, тэгээд эрчим хүчинд нийлүүлж байгаа үнэ хоёрын хооронд зөрөө гарч байгаа юм. Тэгэхээр энэ асуудлыг мөн энэ дэмжлэг энэ хог шатаах асуудал дээр ингээд явах нь энэ цаашдаа байгаль экологийн асуудалд үнэтэй хувь нэмэр оруулах юм гэж үзэж байгаа юм.

2 дугаарт өнөөдөр нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 30 гаран ААН-үүд энэ дахивар бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа. Тэгээд энэ үйлдвэрлэж байгаа үйлдвэрүүдэд ямар нэгэн бодлогын дэмжлэг байхгүй байгаад байгаа юм. Тэгэхээр өнөөдрийн энэ оруулж ирж байгаа тогтоолд маань энэ асуудлуудыг мөн ААН-үүдийг урамшуулсан, тэгээд энэ байгаль экологидоо ээлтэй асуудлыг шийдсэн, татварын хөнгөлөлт, урамшуулал юу байдаг юм энэ дэмжлэгүүдийг оруулж ирэх нь зүйтэй байна гэдэг энэ тогтоол.../минут дуусав/

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Өнөөгийн цаг хугацаанд нэлээн чухал хуульд өөрчлөлт оруулахаар ажиллаж байгаа ажлын хэсэг гэж ойлгож байгаа. Монгол Улс хогон далайд живсэн, хогон дундаа амьдарч байгаа, хогоо өөрсдөө үйлдвэрлэж байгаа, хогоо өөрсдөө тарьж байгаа. Хэд хэдэн асуудал байгаа юм. Үйлдвэрлэгч болон импортлогчийн асуудал байгаа хогон дээр. Энийг татварын ялгамжтай бодлогоор цэгцлэх үү, өөрөөр хэлбэл үйлдвэрлэж байна гэдэг тусдаа асуудал, импортолж оруулж ирээд хаягдаж байгаа хог хаягдлын асуудал тусдаа асуудал гэж ойлгож байгаа. Нэгдүгээрх асуулт нь энэ байна. Ер нь манайх менежментийн гинжин холбоо байхгүй байгаа. Өөрөөр хэлбэл та хэд энэ дээр ерөнхийдөө нөгөө асуудлуудыг нь гаргаж ирэхдээ тавьчихсан байна л даа. Эх үүсвэр дээр ангилан ялгах, дахивар тээвэрлэх тогтолцоо сул гэдэг ч юм уу. Айлууд дээрээ ангилаад байдаг, хогийн цэг рүү явахдаа нэгтгээд аваачаад нэг машинд ачаад аваачаад асгачихдаг ийм хэлбэр байгаа. Энийг бид энэ хариуцлагын тогтолцоо руу нь оруулахгүй бол яг үнэндээ наад орон нутгийн чинь төсөв хог руу зарцуулагдаад, зарцуулагдаад бараг бүтэн төсвөө тавиад ч дийлэхгүй хэмжээнийх байхгүй юу. Тэгэхээр хураамжаар бүх асуудлыг шийдвэрлэхгүй гэдгийг 1 дүгээрт сайн ойлгоосой.

2 дугаарт энэ эгүүлэн татахтай холбоотой асуудал зохицуулалтыг оруулсан байна. Энэ их зөв. Жишээлбэл архины шил өнөөдөр газар сайгүй л хэвтэж байдаг. Тэгвэл архины шилийг буцаан татан авалт хийх, ялангуяа энэ импортын бараа бүтээгдэхүүн дээр буцаан татан авалтыг зайлшгүй хийж байх ёстой. Энийг ААН импортоор орж ирэхээс нь авхуулаад бүртгэлжүүлээд, тухайн бараа бүтээгдэхүүний сав баглаа боодол байдаг юм уу, хаягдах эд зүйлсийг буцаан татах үүрэгжүүлэлтийг, хэрвээ хийхгүй бол өөрсдөө буцаан татдаггүй бол мөнгийг нь гаргаад ёстой нөгөө орон нутгийн төсөв дээр өгч байгаад иргэдээс худалдан авах системээр зохицуулалтыг яг энэ менежментийн тогтолцоо дээр нь гинжин байдлаар их сайн зөв тооцож өгөх ёстой байгаа.

2 дугаар том асуудал байгаа юм худалдааны гэрээ. Бид энийг ерөөсөө ярихгүй байгаа. Өөрөөр хэлбэл Япон улс гэхэд жишээлбэл өнөөдөр хэчнээн их приус машин байна, тэр их батарей өнөөдөр Монгол Улсын газар нутагт буцлагдахаар хэмжээнд очиж байгаа байхгүй юу. Энэ бол аюултай хог хаягдал. Тэгээд энийг Япон улстай жишээлбэл ярихаар манайх худалдааны гэрээтэй, гэрээгээрээ Япончууд танайх руу приус нийлүүлдэггүй, Монголчууд өөрсдөө нийлүүлдэг учраас хариуцлагыг нь бид үүрдэггүй гэдэг зүйлийг ярьдаг. Тэгээд энийг бид яаж хуульчлах вэ? Энийг бид яримаар байна. Ер нь хариуцлагын механизм нь тодорхой бус байгаатай холбоотой асуудал. Яг өнөөдөр энэ хувийн хэвшлийг яаж дэмжих вэ гэдэг механизм сул байгаад байна. Хэрвээ эдийн засагжуулъя гэвэл хувийн хэвшил энэ дээр ажиллаж байгаа хувийн хэвшлийг татвараас хөнгөлөх, чөлөөлөх, эсвэл тухайн үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнийг гадагшаа тээвэрлэж байгаа дээр нь зөвшөөрлийг нь маш хурдан гаргаж өгдөг ч юм уу, эсвэл аюултай хог хаягдлыг гадагшаа тээвэрлэх гэж байгаа, экспортлох гэж байгаа тохиолдолд тухайн зөвшөөрлүүдийг маш хурдан гаргаж өгч, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр булшлагдахгүй байх эрх зүйн харилцааг бид яаралтай хийж өгөх шаардлагатай байгаа.

Нөгөө нэг нь та хэд биччихсэн л байна. Энэ хяналт мэдээллийн тогтолцоо сул байна гээд, нэгдсэн хяналт мэдээллийн бүртгэл ерөөсөө алга байна. Тэгээд энэ дээр яг ахицтай дэвшил гарч чадах уу гэдэг асуулт аваад, ахиад тодруулъя. Баярлалаа.

Б.Бейсен: 4 номер хариулъя.

Б.Дэлгэрбаяр: Бат-Эрдэнэ гишүүний хариултад асуултад хариулъя. Чухал асуудлууд хөндлөө. Үйлдвэрлэгч импортлогчийн хариуцлагын тогтолцооны хүрээнд бид хууль, эрх зүйн орчныг боловсруулахдаа ялгавартай тогтоох гэж байгаа. Үйлдвэрлэгчид маань ер нь Монгол Улсын хэмжээнд хариуцлагатай байдаг. Нийт хог хаягдлын маань бараг 70 орчим хувь нь дандаа импортолж орж ирсэн бүтээгдэхүүнүүд байдаг. Тэгэхээр бид импортолж орж ирж байгаа бүтээгдэхүүний хаягдал дээр тусгайлсан хог хаяг хаягдлын татвар юм уу, хог хаягдлаа буцаан эргүүлж авчрахгүй бол нэмэлт төлбөр төлдөг энэ тогтолцоог үйлдвэрлэгч импортлогчийн эрх зүйн хүрээнд бий болгоно гэж үзэж байгаа.

Гишүүнтэй санал нэг байгаа нь зөвхөн хог хаягдлын хураамжаар манай энэ хог хаягдлын менежментийн зардлыг нөхөх боломжгүй. Ийм учраас бид үйлдвэрлэгч импортлогч хариуцлагынхаа хүрээнд хэрвээ сав баглаа боодлоо буцаан татахгүй бол тодорхой төлбөр төлдөг энэ систем рүү орж байж бид дахивар хог хаягдлаа цуглуулдаг, тээвэрлэдэг, дахин боловсруулах үйлдвэрийг дэмждэг энэ тогтолцоог бий болгоно. Ялангуяа сая эрх зүйн орчноос гадна, манай дахин боловсруулах үйлдвэр дээр нэг тулгамдаж байгаа асуудал нь үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний борлуулалт их бага байдаг учраас санхүүгийн хувьд нэлээн төвөгтэй байдаг. Ялангуяа дахивар хог хаягдлыг боловсруулаад, нэмүү өртөг орж байгаа бүтээгдэхүүн цэвэр түүхий эдээс хийсэн бүтээгдэхүүнээс ялимгүй үнэтэй байдаг. Ингэхээр төрийн худалдан авалт, бусад худалдан авалтад манай дахивраар хийсэн бүтээгдэхүүнүүдийг авах боломжгүй. Үнийн хувьд үнэтэй байна гэдэг. Ийм учраас бид зохих хэмжээнд хууль, эрх зүйн орчинд өөрчлөлт оруулах, ялангуяа төрийн худалдан авалтын үйл ажиллагаанд дахин боловсруулсан бүтээгдэхүүнийг худалдаж авах талаар эрх зүйн зохицуулалтыг оруулна гэж ингэж бодож байгаа.

Хуралдааны гэрээний хувьд приус машин бусад батарейн асуудлаар бид судалж байгаа. Ялангуяа хэрвээ манайд орж ирж байгаа машинуудын ихэнх нь Япондоо байгаль орчны буюу тэр батарейг дахин боловсруулах тэр төлбөрүүдээ төлчихсөн юм оруулж ирж байгаа. Тэгэхээр энийг бид энэ Япон улстай байгуулж байгаа худалдааны гэрээний хүрээнд тэр цугласан мөнгийг буцааж Монгол Улсад оруулж ирж, энэ автомашины хаягдлыг дахин боловсруулах чиглэлээр ажиллах шаардлагатай. Энэ дээр холбогдох яамнууд анхаарах ёстой гэж бодож байна.

Мэдээллийн хувьд гишүүнтэй санал нэг байгаа. Манайд энэ яг хог хаягдлын тоо бүртгэл хангалтгүй. Зөвхөн Улаанбаатар хотын төвлөрсөн 4 хогийн цэг, Хөвсгөл болон 2, 3 аймгууд дээр бид төслийн хүрээнд хог хаягдлыг хэмждэг авто пүү тавьсан. Бусад бүх сумд болон аймгууд дээр ямар нэгэн байдлаар хог хаягдлыг хэмжихгүй байгаа учраас бидэнд яг одоо энэ гарч байгаа 2,7 сая тонн хог хаягдал гэдэг маань яг нэгдсэн тогтвортой, үнэн, зөв мэдээлэл болж чадахгүй байгаа. Ийм учраас Их Хурлын тогтоолд бид ямар ч байсан эхлээд аймгийн аймаг, нийслэлийн төвлөрсөн хогийн цэгүүдийн бүртгэлийн системийг сайжруулах, авто пүүтэй болгох асуудлыг тусгаж оруулж байгаа. Ингэснээрээ бид мэдээллийн тогтолцоог сайжруулна, ялангуяа аюултай хог хаягдлын тооллогыг бид 2014 оноос хойш хийгээгүй байгаа. Улсын хэмжээнд аюултай хог хаягдлын тооллого хийж байж хэчнээн хэмжээний, ямар хаягдал, ямар нөхцөлд хадгалагдаад байгаа юм бэ гэдэг энэ тоо баримтыг бид гаргах нь чухал байгаа. Энийг тогтоолын төсөлд оруулсан байгаа.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Харин тийм, тэгэхээр та хэд маань нөгөө нэг ерөнхий яриад байгаа байхгүй юу. Одоо нэгэнт нэмэлт, өөрчлөлт хийж байгаа яг точный л баймаар байгаа, шууд ингэж шийднэ гэдгээ л хэлчихмээр байгаа байхгүй юу. Санхүүжилтийн асуудалтай холбоотой жишээлбэл орон нутгийн төсөв хүрэлцдэггүй гээд биччихсэн. Энэ дээр ямар шийдэл байгаа вэ, эрх зүйн орчин дээр ямар өөрчлөлт хийж байгаа вэ? Хувийн хэвшлийг дэмжих механизм сул байна гэж байна. Энэ дээр ямар шийдэл байгаа вэ? Жишээлбэл Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар /ААНОАТ/-ын тухай хуулийн татвар ноогдох орлогын нэг хувь хөнгөлдөг гэдэг шиг бодит юм баймаар байгаа байхгүй юу. Монгол Улс чинь хогон далай дотор амьдарч байна, энийгээ яаж шийдэх вэ? Торгууль шийтгэл үр нөлөө багтаа байна гэж байна. Энийгээ яаж шийдэх вэ? Энэ дээр яг тийм, тийм гээд хариулчихмаар байгаа юм нэг.

2 дугаарт Япон улстай байгуулсан худалдааны гэрээн дээр Япон улс тухайн машин автомашин үйлдвэрлэгдээд хэрэглээнд гарснаасаа авхуулаад устгалын зардал жил болгон сууж явдаг. Энэ мөнгийг ямар ч яам тамгын газар авах боломжгүй. Тэгээд энэ Нэгдсэн Үндэстний Байгууллага /НҮБ/ худалдааны гэрээгээр зохицуулагддаг харилцаа.

Б.Бейсен: Ажлын хэсгийн ахлагч Мөнхсоёл гишүүн хариулъя.

Б.Мөнхсоёл: Бат-Эрдэнэ гишүүнийг нэлээн санал өгсөн гэж ойлгосон. 2 дугаарт нь энэ тогтоол дотор Бат-Эрдэнэ гишүүний асууж байгаа энэ тодорхой саналууд боловсруулах үүргийг ЗГ-т өгч байгаа. Энэ өөрөө маш олон жил ужгирчихсан, маш олон ийм судалгаа хэрэгтэй шаардлагатай байгаа учраас чиглэл өгч байгаа. Тэгэхдээ яаман дээр болон нийслэл дээр 2017 он батлагдсан энэ хуулийг нэмэлт, өөрчлөлт оруулах ийм санал явж байна. Энийг одоо шууд авч

хэрэгжүүлэх боломжгүй учраас бид тогтоол гаргаад, дахиж ажиллаад, хуулийн нэмэлт, өөрчлөлтийн саналаа оруулж ирэх ийм саналтай учраас тогтоол батлуулах гэж байгаа шүү.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Харин тийм. Тэгэхээр яах вэ боловсруул тэг л гээд байгаа байхгүй юу. Би сайдаар ажиллаж байсан хүн мэднэ шүү дээ. Тэгээд нэг ерөнхий л юм орж ирнэ яаман дээр. Би тэрийг танд тусгайлаад маш олон цаг ярьж өгч чадна. Өнөөдөр голын эрэг дагасан хогийн цэгүүдийг яах вэ? Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Эгийн голын эрэг дээр хогийн цэг байсан, тэр хогийн цэгийг бид нүүлгэж байсан. Ахиад бусад олон газрууд дээр ийм хогийн цэгүүд байгаа. Энэ дээр жишээлбэл Улсын Их Хурлын тогтоол дээр тэр ерөөсөө ороогүй байна тухайлбал. Мөнхсоёл гишүүнийг би эсэргүүцээгүй шүү, би танд хариулж болно. Хэрвээ надад цаг байгаа бол сайдаар ажиллаж байхад юу хийсэн тухай бидэнд би танд бүтэн тайлан гаргаад өгч чадна. Харин тийм. Тэгэхээр энэ дээр хэдүүлээ нэгэнт тогтоолын төсөл байгаа учраас тэр гол дагасан хогийн цэгүүдийг бид яах вэ, нэгэнт ажлын хэсэг гараад ажилласан бол энэ дээр тодорхой чиглэл өгөх ёстой шүү дээ. Ерөнхий биш, тэрийг л яриад байгаа юм.

Б.Бейсен: Ажлын хэсгээс хэн хариулах уу? 1 номер хариулъя.

Г.Энхмөнх: 2023-аас 2024 онд 21 аймгийн хэмжээнд голын онцгой болон энгийн хамгаалалтын бүсүүд дээр байгаа хур хогийн цэгийн нэгдсэн талбайн хэмжээг тодорхойлсон. Ингээд үндсэндээ 12 аймгийн 10 усны сав газарт үндсэндээ нийтдээ 12 сав газрыг хамарсан 100 гаран га, 100 мянган га талбай орчим газарт хур хог байна гэдэг ийм мэдээлэл зураглалыг Газрын харилцаа, геодези, зураг зүйн газартай нэгтгэн гаргаад, ингээд үндсэндээ 2024 ондоо энэ хур хог хаягдлыг 1,2 тэрбум төгрөгөөр гаргаж, тухайн хог хаягдлыг цэвэрлэж, гол ус, хөрс бохирдох эрсдэлээс бууруулсан ийм дүн мэдээ байгаа. Ингэхдээ тухайн цэвэрлэгээний дараах үр дүнг харахад 475 мянган тонн хог хаягдлыг цэвэрлэж.../минут дуусав/

Б.Бейсен: Пүрэвийн Батчимэг гишүүний асуулт асууя.

П.Батчимэг: Байнгын хорооноос байгуулагдсан энэ Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах энэ ажлын хэсэг бол цаг үеэ олсон яг энэ нийгэмд тулгамдсан асуудлын нэг болох энэ хогийн асуудал өнөөдөр үнэхээрийн тулгамдсан асуудал болсон. Энэ ажлын хэсэг түүнийг дагасан хууль, эрх зүйн орчныг сайжруулах энэ ЗГ-т чиглэл өгөх тогтоолын төслийг өнөөдөр бид батлах юм байна.

Гэхдээ надад 2 асуулт байна. Ажлын хэсэг маань ер нь ажиллаад, өнгөрсөн оны 2025 оны 10 дугаар сард байгуулагдсан санагдаж байна Мөнхсоёл гишүүнээр ахлуулсан. Ажлын хэсэг гайгүй сайн ажилласан юм шиг байна. Олон удаагийн хуралдаан, уулзалт, хэлэлцүүлэг, тэгээд 175 санал энэ тэр авсан юм байна. Гэхдээ өнөөдөр энэ 2024 оны байдлаар Монгол Улсад 2,7 сая тонн хог хаягдал үүсэж байгаа гээд энэ 5 жилийн өмнөхөөс бүүр 35 хувиар өссөн гэж байгаа юм. Тэгвэл энэ энгийн хог хаягдал, аюултай хог хаягдал гээд ингэж байдаг. Тэгэхээр тэрний эзлэх хэмжээ өнөөдөр ер нь ямар байдалтайг ажлын хэсгийнхэн судалж үзсэн үү? Тэгээд ингээд улам өсөж нэмэгдээд байгаа энэ хог хаягдлыг үүсгэж байгаа шалтгаан

болсон хэрэглээг хориглох, хязгаарлах энэ тал дээр дүгнэлт энэ ажлын хэсэг гаргасан уу? Энэ дотор би ер нь олж харсангүй, энийг нэг тодруулаад асуучихъя?э

2009 онд ингээд УИХ-аас зарим нийлэг хальсан уутны хэрэглээг хориглох тухай хууль батлаад, тэгээд дараа нь 12 онд энийгээ хүчингүй болгоод, дахиад ЗГ 2018 онд эргээгээд энэ нийлэг хальсан уутыг хориглох тухай гээд тогтоол гаргачихсан. Энийг тэгвэл яг энэ ажлын хэсэг санал, дүгнэлтэд ер нь яагаад энийг ингээд хуулиа хүчингүй болгоод л, эргээд дахиад л ЗГ нь дахиад л юу гаргачихдаг юм тогтоол гаргачихдаг юм бэ хориглосон энэ дээр та ер нь ажиллав уу? Энэ нийлэг уут хальсан уутны асуудал Монгол оронд бүр гамшгийн хэмжээнд байгаа шүү дээ. Хог хаягдлын бүр аюултай хог хаягдалд орж байгаа, энэтэй санал нэг байна уу?

2 дугаарт ААНБ үүсгэсэн хог хаягдлынхаа хэмжээгээр нөгөө үйлчилгээний хураамж, тариф төлөх энэ эрх зүйн орчин энэ тогтоолд ер нь дагаад явчих юм байна л даа. Тэгэхдээ илүүгээрээ сая Бат-Эрдэнэ гишүүн хэллээ. Илүү ААН-ийг татварын нэг төрөл болох хураамж, тарифаар нь ингээд дарамтлах маягийн тал руугаа л явж байна. Илүү арчаатайхан шиг тийм ажил хэрэгч аж ахуйн том ААН-үүд үйлдвэрээс гарсан хог хаягдлуудаараа дахин боловсруулах үйлдвэр хийгээд өчигдөр энэ тэр шаваад тавьж байгаа харагдаж байна лээ. Тэгэхээр тийм ААН-тэй очиж уулзсан уу? Ер нь төрийн захиргааны байгууллага, яамд, энэ нийслэл, дүүрэг тийм ААН-үүдийг урамшуул.../минут дуусав/

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ? Ажлын хэсгийн ахлагч Мөнхсоёл гишүүн, дараа мэргэжлийн байгууллагаа хариулаарай.

Б.Мөнхсоёл: Сая, танай АПУ компани билүү хог хаягдлыг ашиглах юу гарсан байна лээ шүү дээ үйлдвэр байгуулсан. Бид ТМЛ гээд нөгөө Кока Колагийн дэргэдэх дахин боловсруулах үйлдвэрийнхнийг ажлын хэсэгтээ оруулаад хамтарч ажилласан. Мөн Налайх дүүрэгт энэ нөгөө санал, дүгнэлтэд орчихсон байгаа Налайх дүүргийн тэр дахин боловсруулах гээд байгаа үйлдвэрүүдтэй очиж танилцсан юм. Түүн дотор нэг үйлдвэр нь аюултай хог хаягдал буюу батарей дахин боловсруулах ийм үйлдвэр байсан. Түүнээс улбаалаад бид хар тугалганы асуудлуудыг судалж байгаа. Энд нарийн оруулаагүй, магадгүй Монголд эрүүл мэнд, бусад аюултай байдлыг үүсгэж байгаа бол тусгайлан ажлын хэсэг гарах ёстой юм байна гэсэн ийм санал, дүгнэлт, дүгнэлтэд хүрчихсэн байгаа юм.

Яг тэр иргэдийг хэрэглээг нь хязгаарлах гэдэг маш чухал асуудал. Тэгэхээр энэ дээр илүү судалгаа, нарийвчилсан судалгаа шаардлагатай гэж үзээд, хамгийн гол нь урамшуулах механизмаар буюу хуванцар дахин боловсруулах боломжтой бараа, бүтээгдэхүүний сав суулгыг буцааж тушаах юм бол гэдэг дээр мотивацалж энэ дээр судалгааг илүү гүнзгий хийх ёстой гэсэн ийм үүргийг тогтоолын төсөлд ерөнхийд нь оруулчихсан байгаад байгаа юм. Өөр асуулт юу байлаа, өөр? Манай ажлын хэсгийнхэн нэмээд гүйцээгээд хариулчих.

Б.Бейсен: 4 номер хариулья.

Б.Дэлгэрбаяр: Батчимэг гишүүний асуултад хариулья. Тэгэхээр аюултай хог хаягдал энгийн хог хаягдлын хэмжээ ямар байна вэ гэж асуусан байгаа. 2024 оны байдлаар улсын хэмжээнд 2,7 сая тонн энгийн хог хаягдал гарсан. Аюултай хог хаягдлын хүрээнд 700 мянган тонн аюултай хог хаягдал гарсан гэсэн дүн мэдээ 2024

онд гарсан байгаа. Тэгэхээр 2,7 сая энгийн хог хаягдал, 700 мянган тонн аюултай хог хаягдал гарсан байна гэж үзэж болно.

Хэрэглээ хязгаарлах тал дээр тантай санал нэг байгаа. Ялангуяа бид энэ сав баглаа боодлыг багасгах, үйлдвэрлэгч, импортлогч маань сав баглаа боодлоо дахин боловсруулдаг энэ сав баглаа боодлоор солих асуудлыг бид эрх зүйн хүрээнд тавьж байгаа.

2 дахь гол асуудал таны тавьсан энэ ААНБ үүсгэсэн хог хаягдлынхаа хэмжээгээр төлөх гэдэг дээр бид ямар санал гаргаж байна гэхээр одоо хогоо ААНБ ангилсан ч, ангилаагүй ч юу гэдэг юм нэг тогтмол тариф төрж байгаа 200 мянга ч гэдэг юм уу. Тэгэхээр бидний энэ хууль, эрх зүй.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулья.

Б.Дэлгэрбаяр: Одоо ангилсан, ангилаагүй нэг ижил тариф төлөөд байгаа. Тэгэхээр бид ААНБ дээр ямар боломж гаргаж байна гэхээр үүсгэсэн хэмжээгээр төлнө гэдэг маань бидний хувьд ААНБ эх үүсвэр дээр хогоо бууруулаад ангилбал бага төлнө л гэсэн үг. Одоогийн систем бол ямар ч дэмжих урамшуулал байхгүй. Та их ч гаргасан, бага ч гаргасан ч ижил тариф төлөөд байгаа. Хэрвээ ААНБ хогоо багасгавал бага төлбөр төлнө гэдэг энэ тарифын систем рүү орж байгаа. Дахин боловсруулж байгаа хог хаягдал дээр бид ямар нэгэн байдлаар нэмэлт төлбөр хураамж авахгүй гэсэн ийм тогтолцоо явж байгаа.

Дараагийнх нь нийлэг хальсан ууттай холбоотой эрх зүйн зохицуулалт одоо ч гэсэн хэвээр явж байгаа. Гэхдээ бид мөрдөх боломжгүй байгаа 0,8 микрограммтай нийлэг уут хэрэглэхийг хориглочихсон байгаа. Гэвч энэ маань гаалийн зохицуулалтгүй, хувь хүмүүс оруулж ирж зараад байгаа болохоор энэ дээр хяналт тавихад нэлээн.../минут дуусав/

Б.Бейсен: Пүрэвийн Батчимэг гишүүн тодруулья.

П.Батчимэг: Өнөөдөр харин нэгэнт л энэ ажлын хэсэг хог, хогийн, хог хаягдлын тухай эрх зүйн орчныг сайжруулах тухай ярьж байгаа болохоор би ер нь хамтад нь хог гэдэг утгаар нь яг үнэндээ гэхэд Монгол Улс яг хогийн л орон болчихсон шүү дээ. Хогондоо дарагдчихсан. Тэгээд би хэлээд байгаа нь энэ нийлэг хальсан уутны тэр хуулийг яагаад юу яачихсан юм хориглочихсон юм, тэгээд дахиад яагаад ЗГ нь тогтоол гаргаад дахиад яагаад хориглодог юм бэ? Тэгэхээр энэ талаар энэ ажлын хэсэг бол ажиллах л байсан байхгүй юу. Ажиллах байсан. Тэгэхээр ажиллаагүй байна л гэж би энэ талыг ерөөсөө олж хараагүй байна л гэж үзэх гээд байгаа юм.

Ер нь татварын нэг төрөл энэ хураамж, тариф л яриад байна. Сая өөрөө яриад л байна тийм ээ. Хог их тарьж байгаа ААН бол их л мөнгө төлнө, хураамж төлнө, хог тэрийгээ багасгахын тулд бага л, хэрвээ хогоо л багасгавал бага хураамж төлнө л гээд байна. Энэ.../минут дуусав/

Б.Бейсен: Хэдэн номер хариулах вэ ажлын хэсгээс? 4 номер хариулья.

Б.Дэлгэрбаяр: Би Батчимэг гишүүний хариултад гарчихлаа. Ер нь бид яг энэ ажлын хэсгийнхээ хүрээнд судалгаа хийсэн байгаа юм. ААН-ээс гарч байгаа

холимог хог хаягдлын бүтцээр нь ангилаад үзэхээр нийт хогийн цэг дээр хаяж байгаа хог хаягдлынх нь 30-аас 40 хувь нь дандаа ангилах боломжтой хог хаягдал байгаад байгаа байхгүй юу. Энийгээ нөгөө тариф нь ижил болохоор хүмүүс ерөөсөө шууд хольж ачаад л төлбөрийг нь төлөөд байгаа юм. Тэгэхээр бид бүүр яг СУ гээд сүлжээ дэлгүүр дээр ангилалтын туршилт хийгээд, тэр дэлгүүрээс гарч байгаа хог хаягдлын 30-аас 40 хувь нь дандаа дахивар буюу дахиад эдийн засгийн эргэлтэд оруулах хог хаягдал байгаа. Тэгэхээр энийгээ ААН байгууллагууд эдийн засгийн эргэлтэд оруулаад мөнгө болговол зөвхөн тэр сүлжээ дэлгүүрээс гарч байгаа хог хаягдлын хэмжээ 40-өөс 50 хувиар буурах ийм боломжтой нь харагдаад байгаа юм. Тийм учраас бид энэ ангилан ялгалтыг илүү дэмжсэнээрээ зардал багасгана, ААН-ээс гарч байгаа төлбөрүүд багасаад явах юм байна гэж ингэж харж байгаа.

Б.Бейсен: Пүрэвийн Батчимэг гишүүн тодруулъя.

П.Батчимэг: Ажлын хэсгийн санал, дүгнэлттэй би танилцчихсан харин, бүрэн танилцсан. Тэгэхээр энэ санал, дүгнэлтэд яагаад аюултай хог хаягдал гэдэг энэ нэр томъёолол ороогүй вэ? Огт ороогүй байх юм, хаана байна вэ? Аюултай хог хаягдал, тийм үү? Тэгвэл уучлаарай. Тэгээд ер нь яг энэ хог хаягдал боловсруулах, дахин боловсруулах үйлдвэр яг улсын хэмжээнд хэд байдаг юм бол? Үнэхээр энэ татвар бий болгох тийм ээ, энэ хураамж тогтоох, яг энэ хураамжийг тогтооход яаж хог хаягдлыг ААН дээр очиж яаж хэмжих юм бэ, юугаар хэмжих юм, яаж бүртгэх юм энэ асуудлууд чинь маш бүдэг байна шүү дээ. Хог хаягдлын үйлчилгээний энэ хураамжийг яаж тогтоох юм, тэр механизм нь юу юм бэ?

Б.Бейсен: 4 номер хариулъя.

Б.Дэлгэрбаяр: Улсын хэмжээгээр хог хаягдал дахин боловсруулах 67 үйлдвэр бүртгэлтэй явж байгаа. Үүнээс Улаанбаатар хотод идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 37 үйлдвэр байна, үлдсэн үйлдвэрүүд маань улирлын шинжтэй ажилладаг, зарим үйлдвэрүүд маань зуны улиралд зөвхөн ажиллах ийм байдлаар явдаг байгаа. Нийтдээ 37 үйлдвэр дээр бид Улаанбаатар хотоос гарч байгаа нийт дахин боловсруулах боломжтой хог хаягдлын 12-хон хувийг эдгээр үйлдвэрүүд боловсруулж байна.

Дараагийнх нь ямар асуулт байлаа. Тарифын хувьд яаж хэмжих юм бэ гэдэг. Бид яах вэ одоо Сангийн яам, Байгаль орчны сайд, Сангийн сайдын баталсан юун дээр хог хаягдлын зардалд үндэслэсэн тариф ингээд батлаад явж байгаа. Хэдий хэмжээний зардал гарна тэнд үндэслэсэн. Шинэ тарифын системээр бид энэ зардалд.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

Б.Дэлгэрбаяр: Шинэ тарифын системээр бид энэ зардалд үндэслэсэн биш, гарч байгаа хэмжээ буюу ААН-үүд дээр метр куб эзлэхүүнээр нь хэмжсэн тариф тогтооно гэж үзэж байгаа. Эзлэхүүнээр нь буюу ямар нэгэн ААН бидний судалгаа хийсэн ААН-үүд дээр яг 1м³-ын юм уу, нэг бол 700 литрийн хогийн савнууд байгаа байхгүй юу. Тэр хогийн савнуудыг нь бид яг тэр тариф дээр юу метр куб буюу эзлэхүүнд үндэслэсэн тариф буюу олон улсын жишгээрээ ингэж явна гэж тооцож байгаа. Одоогийн энэ зардалд үндэслэсэн тариф болохоор харилцан адилгүй, том, жижиг ялгаагүй нэг үнэ тогтоочихоор бид зарим нь бага хог гаргадаг нь их төлөөд

байна, их хог гаргадаг нь бага төлөөд байгаа ийм учраас бид энэ эзлэхүүнд суурилсан тариф тогтооно гэж тооцож байгаа.

Б.Бейсен: Сонгобайн Замира гишүүн асуулт асууя.

С.Замира: Энэ ажлын хэсэгт би ажиллаж байгаа. Тэгэхдээ энэ хог хаягдлын хамгийн эцсийн үр дүн нь Монгол даяар хогонд дарагдсан, газрын хөрс нь бохирдсон, агаар нь бохирдсон. Тийм учраас энэ хогийг үйлдвэрт оруулаад, дахин боловсруулаад, ямар нэг аргаар газрыг цэвэрхэн болгох. Тийм учраас би өчигдөр ажлын хэсгийн хурал дээр нэг зарчмын зөрүүтэй санал хэлсэн юм, энэ ороогүй байх юм. Хамгийн гол нь бид энэ хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр тоног, төхөөрөмж оруулъя гэсэн ААН-үүдийг дэмжиж, гаалийн татвараас чөлөөлөх ёстой гэсэн санал хэлсэн 1 дүгээрт.

2 дугаарт, татвараас манайхан ямар боломж байна, тэрнийг 5-аас 10 жилийн хугацаанд татвараас чөлөөлөх. Тэгж байж бид ААН-үүдийг дэмжсэнээрээ ингээд энэ хогоос, хогийн юунаас цэгүүдээс бид газраа чөлөөлөх боломжтой л гэсэн нэг зарчмын зөрүүтэй санал хэлсэн л дээ. Энэ ороогүй байна. Тэгээд ААН-үүдэд хогийн хэмжээгээр бид татвар, хураамж гээд яриад байна шүү дээ. Энэ нь яах вэ ер нь формалдсан юм болов уу гээд би бодож байна. Яагаад гэвэл тэрнийг хэмжих боломж байхгүй. Тэгээд ч үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийг дээрээс нь дарамт шахалт үзүүлэх гээд байгаа юм шиг нэг санал юу бодол төрөөд байна л даа. Тийм учраас энийг миний зарчмын зөрүүтэй саналыг оруулж өгнө үү албан ёсоор. Баярлалаа.

Б.Бейсен: Мөнхсоёл гишүүн хариулъя.

Б.Мөнхсоёл: Замира гишүүн маань өөрөө хэллээ. Ажлын хэсэгт байгаа гишүүдийн маань 1. Өчигдөр ажлын хэсэг хуралдаад, энэ тогтоолоо саналаа батламжилсан. Тэрэн дээр Замира гишүүн энэ саналыг хэлсэн, орсон байгаа шүү.

Батчимэг гишүүний хэлсэн дээр зүгээр нэмээд тодруулга ганц өгүүлбэр хэлэхэд ер нь энэ өргөтгөсөн хариуцлагын механизм гэдэг нь олон улсын түвшинд ялангуяа өндөр хөгжчихсэн улсуудад нэвтэрчихсэн ийм механизм. Монголд энэ 17 оныхоо хуульд орсон. Гэхдээ хэрэгжилт муу байгаа нь түрүүн бид ярьсан олон шалтгаантай. Тэгэхдээ энэ 2 талын мэдээж нөгөө хог гарах тусам төлбөр ихсэх нь байна шүү дээ төлөх төлбөр нь. Нөгөө талдаа хог бага гаргаад байгаа мөртөө тогтмол ижилхэн үнэтэй төлбөр тариф төлөөд байгаа нь шударга биш болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ дээр нэг талдаа төлбөрийг чөлөөлөх, үүсгэсэн нь төлбөрөө төлнө, нөгөө талдаа үйлдвэрлэгчдээ дахин боловсруулаад гаргасан хог хаягдлаа эргүүлэн авч цуглуулах гэх мэт зүйлийг нь урамшуулах татварын хөнгөлөлт, гаалийн хөнгөлөлт, НӨАТ-ын татварын хөнгөлөлт гэдэг ийм урамшууллын механизмыг давхар бий болгох гээд байгаа юм. Тэгэхээр энэ холимог янз бүрийн механизмуудыг л оруулж ирнэ гэсэн үг. Тэгээд бид олон удаагийн хэлэлцүүлэг хийсэн.

Энэ хог хаягдлын асуудал Монголыг бүүр бүрхчихсэн, тэгээд энэ нийслэл бол зарим нэг асуудлыг яам руугаа, яам нь нийслэл рүүгээ ингэж эзэнгүйдэж байгаа асуудлуудыг бүгдээрээ энэ улсын иргэн хүний хувьд, хотын иргэн хүний хувьд, иргэдийн хувьд шийдэх хэрэгтэй л гээд ийм ЗГ-т чиглэл өгөх гээд байна. Хууль дээр шууд нэмэлт, өөрчлөлт ороход манай сайд асан Бат-Эрдэнэ гишүүний хэлсэнчлэн

амаргүй, маш сайн гүн бодох ёстой асуудлууд байгаа учраас ЗГ-ыг ажиллуулах гээд байгаа ийм хувилбарыг сонгосон шүү. Баярлалаа.

Б.Бейсен: Алтаншагай гишүүн асуулт асууя.

Н.Алтаншагай: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе. Энэ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам гээд энэ яг энэ хог хаягдлын чиглэлээр бодлого гаргах ёстой яам нь гэж бодож байгаа. Тэгээд ажлын хэсэг Улаанчулуутын хойгийн цэг дээр очоод ажиллахад нэг мэргэжилтэн л байна гэж ойлгосон доо. Тэр яг хэлтэс, албад гэж байна уу, яг хариуцсан тийм референт, мэргэжилтэн гэж байна уу 1 дүгээрт тэрийг асууя?

Тэр хариуцсан яаман дээр нь ерөнхийдөө ямар ч ойлголт байхгүй юм байна лээ шүү. Амьдралаас аягүй хол, юм асуухаар ерөнхийдөө нэг өөрсдийгөө тийм өмөөрсөн байдалтай байна лээ. Амьдрал дээр энэ чинь өөрөө яг өдөр тутам тулгамдаж байгаа маш хүндрэлтэй асуудал шүү дээ. Гэр хорооллоос хогийг яаж татан төвлөрүүлж тэр юу руу хогийн цэг рүү аваачдаг юм, орон сууцнаас яаж аваачдаг юм гээд, тэгээд ялган ангилах энэ тэр гээд ингээд яривал маш хүнд. Тэгээд энэ дээр нөгөө тогтоолын төсөл дээр ганц нэг нэмэлт санал оруулах саналыг тийм нээлттэй байх тийм ээ. Ажлын хэсгийн даргад санал болгож байгаа юм.

Энэ зарим дүүргүүдээр иргэдийн бүлэг гээд гарсан юм. Дүүрэг болон хороодын нутаг дэвсгэрийн залгаа зааг, эзэнгүй орхичихсон тэр бүсүүдийн хогийг гаргаж цэвэрлэдэг, урамшууллыг нь дүүргийн иргэдийн хурал төсөв дээрээ тавиад шийдэж байсан. Энэ үнэхээр бодитой сайн ажил байхгүй юу. Тэгэхээр энийг нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд энэ төрийн захиргааны байгууллагууд, 21 аймаг, 9 дүүрэг, 330 сумын хэмжээнд тусгаад өгвөл төсөв дээрээ тавиад энэ асуудлыг шийдэх боломжтой. Хүний хүч багадахгүй. Тэгэхээр энэ дээр нэг шийдэл гаргаач гээд. Энэ орон нутгийн төсөв дээр тодорхой заалтуудыг оруулж яг хуульчилдаг юм уу? Төсөв дээр нь нэмэлт тавьж өгөхгүй бол тухайн аймаг, сум, дүүргүүд харилцан адилгүй яваад байгаа, нэг загвар луу орохгүй бол энэ тун төвөгтэй.

Тэгээд олон гишүүд хэлж байгаа энэ нийт Монгол Улсын нутаг дэвсгэр өөрөө ийм хогонд дарагдсан ийм хүнд байдалтай байгаа. Одоо авч байгаа хамгийн сайн арга хэмжээ нь Улаанбаатар хотын тойрсон 2, 3 хогийн цэг дээр энэ Улаанбаатарынхан хогоо аваачиж булдаг, булшилдаг, тэгээд landfill аргаар, тэгээд янз бүрийн хий ялгардаг гээд байгаа юм. Тэгээд хотын болон энэ Байгаль орчны яамныхан энэ хог шатаах, дахин боловсруулах, эрчим хүч гаргах энэ үйлдвэр лүүгээ л яаралтай шилжих нь хамгийн оновчтой, өөр гарц гаргалгаа байхгүй. Дандаа энэ байгаль эхийнхээ хэвлий рүү энэ хогоо булаад булшлаад байна гэж байхгүй.

Дараачийнх нь гарах энэ үр дагавар, хор хөнөөл маш их. Тэгэхээр энэ тэр шүүхийн шатанд явж байгаа тэр маргаантай байгаа зүйлүүдээ хот дээр байгаа энэ төслүүд маань яаралтай эцэслэн шийдвэрлэж, тэр хог шатааж дахин боловсруулж, эрчим хүч гаргах энэ ажил руугаа шилжих нь зүйтэй гэсэн ийм саналыг би дахин, дахин илэрхийлсэн. Тэгээд ажлын хэсгийн даргад хэлэхэд энэ иргэдийн бүлгийг нь нийт энэ 21 аймаг, 9 дүүрэг, 330 сумын хэмжээнд ажиллуулах ийм тогтоолын төсөл дээр санал.../минут дуусав/

Б.Бейсен: Санал хэлсэн үү тийм ээ? Алтаншагай гишүүн санал хэллээ. Ажлын хэсгийн танилцуулгатай танилцлаа. Хэд хэдэн асуудал асууя. Энэ

аймгуудын төвийн хог хаягдлын асуудал, Улаанбаатар хотын хог хаягдлын асуудал нэлээн сайнгүй байгаа. Аймагууд дээр ялангуяа малын түүхий эд, дотор эрхтэн нядалгааны газрууд зүгээр хогийн цэг рүү асгаж байгаа. Нөгөөдөх нь дулаараад ирэхээр өмхийрөөд халдварт өвчин гарах нөхцөл бүрдэж байгаа. Тийм учраас энэ Байгаль орчны яамныхан Хөдөө аж ахуйн яамтай хамтраад энэ дээр төсөл хэрэгжүүлээд дахин боловсруулах үйлдвэрийн асуудлыг шийдэх талаар ямар бодлого барьж байна вэ?

2 дахь асуудал энэ Дэлүүн сумаас эх авдаг Буянт гол байгаа. Ховд аймгаас ингээд гомдол ирж байсан. Тэгээд энэ Буянт гол маань Ховд аймгийн төвөөр дайрдаг, Дэлүүн сумын хогийн цэг нь Буянт голын эхэнд байдаг гээд энэ Одонтуяа сайд байхад асуудал гараад, Одонтуяа сайд нэлээн арга хэмжээ авч байсан. Энэ хогийн цэгийг нүүлгэсэн үү ер нь, яаж шийдсэн бэ?

3 дахь асуудал хог хаягдлын урамшууллын асуудал байгаа юм. Нэлээн хэдэн тэрбумаар урамшуулал авдаг мөртөө цуглуулж байгаад дахиж булдаг асуудал байгаа юм. Хэчнээн байгууллага, хэчнээн тэрбум төгрөгийн урамшуулал авсан бэ? Энэ дахин боловсруулах үйлдвэрийнхэн авсан уу, аль эсвэл зүгээр гомдол ирж байгаа энэ зүгээр адилхан цуглуулж байгаад булдаг байгууллагууд нь энэ урамшуулал авдаг гээд.

4 дэх нь эмнэлгийн хог хаягдлын асуудал байгаа. 21 аймаг, 9 дүүрэг, Улаанбаатар хотод эмнэлгийн хог хаягдал маш ихээр гарч байгаа. Энэний дахин боловсруулах үйлдвэр байна уу? Ялангуяа энэ хог хаягдал дээр төмрийн хаягдал, шприц, гялгар уутны хаягдал, цаас, картон цаасны хаягдал, шилний хаягдал, даавууны хаягдал, тэгээд малын яс, эврийн асуудал байгаа. Эд нар дахин боловсруулах үйлдвэр дээр маш чухал түүхий эд болдог. Энийг ялгаж цуглуулж байгаа талаар ер нь хэр ажиллаж байна вэ? Ялангуяа энэ албан байгууллага, ААН, сургууль, цэцэрлэг, айл өрхийн түвшинд сургалт сурталчилгаа хийж байгаа юм байна уу? Энэ талаар асууя, дараа тодруулъя. Хэдэн номер хариулах вэ? 2 номер хариулъя.

Ш.Батбаяр: Бейсен гишүүний асуултад хариулъя. Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумтай холбоотой хогийн цэгээр холбоотой асуудлыг хариулъя. 2024 онд мэргэжлийн байгууллагын хийсэн шинжилгээгээр Буянт голын эхэн болон дунд, адагт бол их хэмжээний бохирдол илэрсэн. Үүнтэй холбоотойгоор манай Усны газар болон Хар нуур, Ховд голын сав газрын захиргаанаас газар дээр нь ажилласан байгаа. Энэ дээр Дэлүүн суманд 1971 оноос хойш хуримтлагдсан 54 га талбай бүхий хогийн цэг байсан. Тэгээд үүнийг зайлуулах, багасгах, нөхөн сэргээх ажлын төсвийг гаргахад 680 сая төгрөг шаардлагатай болсон. Тэгээд 24 оны улсын төсөвт 5 га газрыг 76 сая төгрөгөөр булшилсан байна. Тэгээд мөн Дэлүүн сумын Орчлон орд гээд уул уурхайн компани нийгмийн хариуцлагынхаа хүрээнд 231 сая төгрөгийг гаргаж, 54 га байсан талбайг цэвэрлэн, 2 га талбай болгосон байгаа. Тэгээд ойрын хугацаанд 2 га газар талбайг Азийн хөгжлийн банк /АХБ/-ны санхүүжилтээр нүүлгэн шилжүүлэх ажлыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Нэмэлт мэдээлэл өгөхөд Буянт голын бохирдол дээр 2 үндсэн эх үүсвэр байсан байна. Эхний үүсвэр бол сая Дэлүүн сумын хог, хогийн цэг байна. 2 дахь нь Ховд аймгийн Жаргалант сумын иргэдийн гол дээр байршдаг зусдаг асуудал байгаа. Тэгээд энэ талаар нь манай мэргэжлийн байгууллага Жаргалант сумын иргэдийн

хуралд зөвлөмж өгсөн байгаа. Тэгээд тодорхой хугацаанд нөхөн сэргээлтийг хийгдэж дуустал нүхэн жорлон, гэрийн буйр, өвс ургамлыг сэргэтэл айл буулгахгүй байх зөвлөмжийг өгсөн байгаа. Тэгээд иргэдийн хурал тодорхой шийдвэр гаргана гэж найдаж байна.

Б.Бейсен: Дэлүүн сум дээр хэдэн сая төгрөг гэнэ вэ? 2 номер.

Ш.Батбаяр: 24 онд улсын төсвөөс 76 сая төгрөг зарцуулж, 5 га газрыг нүүлгэн шилжүүлж цэвэрлэсэн байна. Уул уурхайн компаниуд нийгмийн хариуцлагын хүрээнд 231 сая төгрөгийг зарцуулж, 5 га, 2 га газар хүртэл багасгасан байна. Тэгээд үлдсэн 2 га газрыг нь 27 онд АХБ-ны санхүүжилтээр төслөөр цэвэрлэхээр, нүүлгэн шилжүүлэхээр ажиллаж байгаа. Ер нь анх 680 сая төгрөгийн төсөвтэй төсөв гарсан байгаа нүүлгэн шилжүүлэх. Одоо бол 2 га газар л үлдсэн гэсэн үг.

Б.Бейсен: Эмнэлгийн хог хаягдлын асуудлаар нөгөө түүхий эд ялган цуглуулах талаар хэн хариулах вэ? 1 номер хариулъя.

Г.Энхмөнх: Эмнэлгийн хог хаягдлын хувьд 2020 оноос 2025 он хүртэлх тоо статистикийг харахад ковидын үед нэмэгдсэн байдалтай. Одоогийн байдлаар эмнэлгийн хог хаягдлуудыг шийдвэрлээд явж байгаа асуудал тухайн эмнэлгүүд дээр автоклав байршуулах, мөн энэ эмнэлгийн хог хаягдлыг устгах тусгай зөвшөөрөлтэй 3 үйлдвэрүүдэд нийлүүлэх замаар эмнэлгийн хог хаягдлыг устгах энэ үйл ажиллагаа явагдаж байна. Мөн таны түрүүнд асуусан тэр соён гэгээрүүлэхтэй холбоотой асуудал байна. Соён гэгээрүүлэхтэй холбоотой асуудлаар хуучин 2017 онд батлагдсан шинэчилсэн найруулга хийгдсэн Хог хаягдлын тухай хууль дээр энэ боловсролын байгууллагын чиг үүрэгт хог хаягдлын талаарх мэдээлэл өгөхтэй холбоотой асуудал 2023 онд хуулиас хуульд өөрчлөлт ороод байхгүй болсон. Тэгээд бид энэ хуулийн нэмэлт.../минут дуусав/

Б.Бейсен: 1 номер гүйцээж хариулъя.

Г.Энхмөнх: Нэмэлт, өөрчлөлтөөрөө хог хаягдлын талаар бага ангийн, бага ангиас нь эхлээд хог ангилан ялгахтай холбоотой соён гэгээрүүлэх ажлуудыг зайлшгүй оруулах шаардлагатай гэдэг үүднээс хуулийн шинэчилсэн нэмэлт, өөрчлөлтөөр оруулаад явж байгаа. Нөгөө талаасаа энэ хог хаягдлын жишиг сумуудын загварыг бусад сумуудад бий болгох хүрээнд одоогийн байдлаар улсын хэмжээнд 17 сумыг сонгоод, ингээд Булган аймгийн Хишиг-Өндөр суманд хэрэгжиж байгаа жишиг хог хаягдлын цэгийн менежментийг бусад 17 сумуудад хэрэгжүүлэх ажил хийгдэж байна. Нөгөө талаасаа бид энэ дахин боловсруулах боломжтой хог хаягдлын талаарх холбогдох хуванцаргүй аян гэдэг юм уу хуванцаргүй COP гэх мэтчилнээр тодорхой нөлөөллийн аянуудыг үе шаттайгаар хэрэгжүүлээд явж байгаа.

Б.Бейсен: 5 номер хариулъя.

М.Үнэнбат: Гишүүний асуултад хариулъя. Энэ урамшуулал олгохтой холбоотой зохицуулалтын талаар ер нь Хог хаягдлын хууль дээр тодорхой зохицуулалт байгаа. Тэгэхдээ энэ яаж байна вэ гэхээр тодорхой төрлийн импортлогч үйлдвэрлэгчдийг хог хаягдлаас урамшуулал олгохгүй заалттай. Тэр нь юу байна гэвэл саяын тэр нийлэг уут гэдэг юм уу, аюултай хог хаягдлыг импортлогч үйлдвэрлэгчийн тухайд урамшуулал олгох зохицуулалт байхгүй. Харин зүгээр

энгийн хог хаягдлыг цуглуулах, боловсруулах, дахин боловсруулах гээд урамшуулал олгох заалт байгаа хэдий ч энэ нь нөгөө талдаа төсвөөс урамшуулал олгож болно гээд заачихсан байгаа. Тэгэхдээ төсвөөс хэрхэн, яаж урамшуулах талаар зохицуулалт хуульд байхгүй. Тийм учраас энийг журамлах боломжгүй болчихоод байгаа. Тэр нь юу байна вэ гэхээр Захиргааны ерөнхий хууль дээр аливаа урамшуулал олгох тохиолдолд заавал ч үгүй эрх олгогдсон заалт байдаг. Тэр эрх олгогдсон хэмжээний хүрээнд иргэдийн хурал нь байдаг юм уу, Засаг дарга нь байдаг юм уу тэр хүрээндээ журамлаж байж урамшуулах олгох эрх зүйн үндэс нь нээгдэх ёстой. Тэгэхээр яг хууль дээр байгаа энэ зохицуулалтыг хэрэглэх.../минут дуусав/

Б.Бейсен: 4 номер гүйцээж хариулъя.

М.Үнэнбат: Тэгэхээр өнөөдрийн тухайд энэ хуулийн заалтыг хэрэглэх бололцоогүй болчихоод байгаа юм. Тэгэхээр бид бүхний саяын энэ тогтоол дээр тусгаад байгаа нэг зүйл иргэд, ААН-ийг энэ экологид ээлтэйгээр энэ хогоо дахин боловсруулж байгаа, дахин сэргээн ашиглаж байгаа энэ тохиолдолд энийг нь ямар урамшуулал олгодог байх юм бэ гэдгийг судалгааны үндсэн дээр, хуулийн төсөлдөө дахиж энэ хуулийг хэрэгжих нөхцөлийг нь бүрдүүлэх зорилго нь зүйтэй байна гээд. Тийм учраас эрх зүйн үндсийг нь зөв болгооч гэдэг тогтоол дээр энэ асуудал тусгагдсан байгаа.

Өнөөдрийн байдлаар энэ урамшуулал авсан нэг ч компани, ААН байхгүй. Тэгэхээр бид бүхэн энийг нь энэ зах зээлийн зарчим руу нийцүүлээд, ямар тохиолдолд урамшуулал олгож болох юм, тэр нь ямар хэлбэртэй байх юм, тарифын хөнгөлөлт байх юм уу, аль эсвэл олгодог мөнгөнөөс нь урамшуулах юм уу гээд энэ олон асуудлыг судалж байгаад, энэ хуулийг зөв хэрэгжүүлэх, нэг мөр болгох нь зүйтэй юм гэж тогтоолын төсөлдөө тусгачихсан байж байгаа.

Б.Бейсен: Энэ урамшуулал өнгөрсөн жил авсан байгууллагууд байдаг юм байна тэрбум 500 хүртэл. Энийг чинь яаж, хэнээсээ юуг нь авах вэ эд ер нь 1 дүгээрт. 2 дугаарт энэ ажлын хэсгийнхэн Мөнхсоёл гишүүн тогтоолд энэ дахин боловсруулах ялгах асуудал дээр улсын төсөв дээр Байгаль орчны яам бас юу тавиад, аймгууд дээр чинь Орон нутаг хөгжүүлэх сан дээр хуучныг бодвол маш их төсөв тавигддаг болсон. Тодорхой хэмжээний хувийг нь 70 хувийг нь улсын төсвөөс ч юм уу, 30 хувийг нь орон нутгаас гаргаад тийм дахин боловсруулах үйлдвэрийн асуудал дээр тогтоолын төсөлдөө оруулаад, шийдвэрлэх талаар анхаараарай гэж хэлье.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Замира гишүүнээр тасалъя. Замира гишүүн асуулт асууя.

С.Замира: Асуулт биш. Саяын хэлсэн асуултыг дахиад давтан хэлэх гээд байна. Яагаад гэвэл нэгэнт ЗГ-т чиглэл өгөх гэж байгаа учраас Монгол орон хогноос ангижрахын төлөө бид аль болох хог боловсруулах үйлдвэрүүдийг нэмэх ёстой. Нэмэхийн төлөө төр засаг ямар хөнгөлөлт үзүүлэх вэ гэхээр нь гаалийн татвараас чөлөөлөх ААН-үүдийг, тэгээд 5-аас 10 жилийн хугацаанд гэж зааж өгөх хэрэгтэй. Татвараас бас хөнгөлөх. Энэ яагаад хугацаа заагаад вэ гэвэл нэг ЗГ нь ирээд нэг шийдвэр гаргаад юу батлахад, дараачийн ЗГ нь ирээд тэрнийг үгүйсгээд ингээд үгүй болгочихдог. Тэрнээс болоод ер нь манай Монгол орны хөгжил ч хойшоо татагдаад

байгаа шүү дээ. Тийм учраас энийг албан ёсны нэг заалт болгоод оруулж өгөх цаашдаа анхаарал тавина уу гээд ажлын хэсгээс хүсэх байна. Баярлалаа.

Б.Бейсен: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тогтоолын төсөл нэлээн дутуу байна. Яамныхан маань уул нь сайн л ажилладаг, түрүүн Алтаншагай гишүүн нэг хүн байсан гээд байсан. Тэр үед нь л тэгж таарсан юм болов уу гэж би ойлгож байна Байгаль орчин, аялал жуулчлалын яам, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас Одонтуяа сайд ч мэдэж байгаа байх, яг энэ хог хаягдал дээр нэлээн төвлөрч ажилладаг гэдгийг 1 дүгээрт хэлэх гэж байгаа юм.

2 дугаарт, төрийн захиргааны байгууллагуудын чиг үүргийг бид аягүй сайн тодорхой болгож өгмөөр байна. Тэгэхгүй бол энд өнөөдөр Улсын Их Хурлын тогтоол гараад, төр захиргааны байгууллагуудад чиглэл өгөөд ч давхардсан бүтэцтэй хэлбэр дээр энэ ерөөсөө явахгүй. Тэгэхээр энийг 1 дүгээрт оруулж өгөөсэй гэж хүсэж байгаа юм.

2 дугаарт, өнөөдөр энэ Улсын Их Хурлын тогтоол ажлын хэсэг маань яах вэ ажилласан байна. Гэхдээ холбоос алга, холбоос алга, дутуу үзсэн байна гэсэн үг. Жишээлбэл уул уурхайн хог хаягдал байхгүй байна, уул уурхайн хог хаягдал буюу тэр том, том машины дугуйнуудыг өнөөдөр яаж байгаа билээ, та нар өөрсдөө надаар хэлүүлэлгүй мэдэж байгаа шүү дээ. Уул уурхайн хог хаягдлыг бид яах вэ гэдэг нэг ч зүйл, заалт энэ дотор алга.

2 дугаарт, түрүүн Бейсен дарга бас хэлсэн. Эмнэлгийн хог хаягдлын холбоотой асуудлыг яах юм бэ гэдэг асуудал байна. Энэ дутуу байна. Гол, мөрөн дагасан хог хаягдлын цэгүүдийг бид яах ёстой вэ, тэр бол ганцхан сумд нөлөөлж байгаа асуудал биш, тэр голоор дамжаад маш олон суурин газарт ууж байгаа мал, хүн бүгдэд нь нөлөөлж байгаа нөлөөллийн асуудал байхгүй юу. Тэгээд энэ ерөөсөө тусгагдаагүй байна. Энийг хэдүүлээ шийдэх ёстой.

Худалдааны гэрээгээр зохицуулагдаж байгаа импортын бараа, бүтээгдэхүүнтэй холбоотой асуудал дээр бид ямар шийдэл гаргах ёстой вэ гэдгээ бодох ёстой, энэ ер нь тусгагдаагүй байна. Зүгээр ерөнхий байна. Тэгэхдээ шийднэ гээд байгаа боловч худалдааны гэрээг бид хөндөхгүйгээр энэ асуудлыг шийдэх боломжгүй шүү дээ.

Дээрээс нь 7 дээр хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагаанд төсвөөс олгож байгаа татаасыг үе шаттай бууруулах гэдэг заалт байгаа. Бид саяын Замира гишүүний хэлдэг боловсруулах тал руу ормоор байгаа байхгүй юу. Төрийн татаас өөрөө цуглуулах, тээвэрлэх, булшлах дээр яваад баймааргүй байгаа. Энийгээ хэдүүлээ их сайн мэдэж, тодорхой хэмжээнд үүрэг, чиглэл дээр оруулах нь зөв болов уу гэж зүгээр би бодож байна. Энэ дахин ашиглах үйлдвэрийг бид чухалчлах ёстой. Энэ дээр байна л даа, яах вэ яагаад судалгаа нь ингэж орсныг би сайн мэдэхгүй байна. Жишээ нь 8 дээр аймаг, нийслэл, сумын, аймаг, нийслэл, улсын зэрэглэлтэй хотын хог хаягдлын төвлөрсөн цэгт дахин боловсруулах боломжтой дахивар нөөцийг хүлээн авсан тохиолдолд нэгж тарифаас өндөр төлбөр тогтоох механизмыг бүрдүүлэх гээд л орчихсон байна. Яг өнөөдөр ний нуугүй хэлэхэд хог хаягдлаа ангилаад авч болж байна, цуглуулж байна, асуудал алга.

Тэрийг хот суурин газар дээр ихэнх үйлдвэрүүд нь төвлөрч байгаа учраас татах гэж тээвэрлэлтийн зардал талдаа хүрээд л, тухайн хог хаягдал цуглуулсан бүх мөнгө нь дуусчхаад байгаа байхгүй юу. Тэгээд алдагдалтай гэсэн үг. Тэгэхээр энийг бид яаж жишээ нь бүсчилсэн хэлбэр гээд нэгэнт бүсчилсэн сонгууль явагдсан энэ цаг хугацаанд явж байгаа учраас энийг бид яаж оруулах вэ гэдгээ маш зөв тооцож оруулах шаардлагатай. Би бол Хэнтий аймгийн Дадал сумыг шууд хэлмээр байна. Хэнтий аймгийн Дадал сум дээр шууд хуваарилалт хийгээд авч байгаа. Тэр нь өөрөө Улаанбаатар хот хүрэх зардалдаа чүйтэй айтай зардал нь хүрээд л дуусчхаад байгаа байхгүй юу. Нөгөө ямар ч ашиг байхгүй. Тэгэхээр ямар ч хувийн хэвшил орох бололцоо байхгүй байна гэсэн үг. Тэгээд энийгээ бид яаж шийдэх вэ гэдэг ч юм уу гэх мэтчилнээс авхуулаад ингээд Улсын Их Хурлын тогтоол дээр нэлээн олон зүйлийг, нэгэнт Улсын Их Хурлын тогтоол гарах гээд ажлын хэсэг ажиллаж байгаа учраас, дээрээс нь хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулахад жоохон хэцүү байна гэж байгаа учраас энэ Улсын Их Хурлын тогтоолоо хэдүүлээ илүү чамбайруулж, цогц түвшинд нь менежментийг гинжин урвал дээр нь харж л тооцож хэдүүлээ Улсын Их Хурлын тогтоолынхоо зүйл, заалтыг оруулж, ЗГ-т үүрэгжүүлээд явах нь зөв болов уу.

Та хэд маань менежмент гэдэг үгээ их сайн хараасай гэж бодож байна. Тэгээд яах вэ сүүлийн үед энэ Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам маань энэ дээр ажиллаж байгаа болов уу гэж ойлгож байгаа. Батбаяр ТНБД-тай олон удаа холбогдож байгаа, өдөр, шөнөгүй л ажиллаж байгаа сураг байдаг. Тэгээд цаашдаа та хэд маань энэ дээр хичээж ажиллаасай. Тийм учраас энэ дээр саяын саналуудыг би шууд өнгөцхөн харахад жишээлбэл ийм саналууд жишээлбэл байна.

Б.Бейсен: Салдангийн Одонтуяа гишүүн үг хэлье.

С.Одонтуяа: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тэгэхээр яах вэ манай дээр ер нь энд, тэнд харж байхад нэг ажлын хэсэг байгуулагдаад, дарга нь нэлээн л гүйдэг юм даа хөөрхий. Хэдэн сар л Мөнхсоёл энэ ажлын хэсгээ ахлаад л гүйгээд байсан. Яах вэ гишүүдийн оролцоо ер нь их л бага байдаг юм, 1, 2 санал өгвөл өгчхөөд, гол ажлын хэсгийн дарга л хамгийг үүрч байгаа юм. Тэгэхээр одоо энэ их олон сар ажилласан юман дээр нь бид саналаа өгөөд, гишүүд саналаа бичгээр өгөөд, тэгээд тогтоолын төсөлд нэмэлт дээр нь оруулаад, тэгээд энэ тогтоолыг хурдан баталбал зүгээр байх гэсэн саналтай байна.

Ер нь энэ нэг хог хаягдал дээр хэд хэдэн асуудал байгаа юм л даа. Нэг нь тарифын асуудал байдаг. Жишээлэхэд, Мөрөн, Хөвсгөл Мөрөнд ингээд ерөөсөө хоггүй болчихсон гээд хүмүүс нь юунаас болов гэсэн чинь орон нутаг нь тарифаа нэмсэн. Нэг өрхөөс сарын авдаг мөнгө нь 10 мянган төгрөг болсон байхгүй юу. Тэгэнгүүт тэнд иргэдийн хурлынхан маргаан гарах болов уу, их гэх болов уу гэсэн чинь ерөөсөө иргэд маргаан гаргаагүй, 10 мянга төлөөд, ингээд хот хоггүй болсон. Сая Сонгинохайрханыг асуусан 8500 авдаг юм байна. Зарим дүүрэг бүүр 2500 байсан шүү дээ, яаж нэг айлын хогийг бүтэн сар тээчхээд 3, 4 мянган төгрөг авах юм, энэ чинь хүрэхгүй байхгүй юу. Тэгэхээр энэ тарифыг нэмэх асуудал дээр маш сайн ажиллах хэрэгтэй гэж үзэж байна.

2 дугаарт энэ жишиг сум гээд нэг төсөл гарсан шүү дээ хогийн асуудал дээр Хишиг-Өндөр сум. Түүн шиг жишиг хороо гэдэг нэг ийм төсөл хэрэгжүүлэх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл хүн бүхэн очоод ерөөсөө хороо чинь ямар байх юм, гэр хороолол

нь, байшин хороолол нь ямар байх юм бэ гэдэг нэг ийм жишиг зүйл гаргах шаардлагатай. Яагаад гэхээр гол хогийн чинь объём юун дээр явж байна гэхээр ангилахгүйгээсээ яваад байгаа байхгүй юу. Жишээлэхэд би орон сууцад амьдардаг, би бол хогоо бараг ангилж чадахгүй байгаа. Яагаад гэхээр тийм нөхцөл нь байхгүй.

Гэтэл би БГД-ийн Засаг даргаар ажиллаж байхад нэг орцыг ингээд бид загвар болгоод, орцны давхар болгонд нэг ийм жижигхэн хайрцгууд хийж туршиж үзсэн юм. Цэвэрхэн нөгөө цаасны хог, тэгээд шил. Тэгэнгүүт хогийн объём ч эрс багасчхаж байгаа байхгүй юу. Тэгээд жижүүрүүд нь нөгөө юмаа аваад, өөрсдөө тушаагаад, жоохон мөнгөө олдог. Тэгэхээр ангилаагүй хогийг одоо авдаггүй болмоор байна. Ямар ч газраас ангилаагүй хогийг авдаггүй. Хөдөө орон нутаг чинь ангилаад ачаад байна шүү дээ. Гэтэл хот нь ингээд ангилахгүй байх юм. Тэгэхээр энэ бол хогийн хамгийн том проблем шүү. Тэгэхээр ангилахгүй хогийг л бид авахгүй байх ёстой гэж үзэж байна.

Дээрээс нь энд нэг чухал заалт Мөнхсоёл гишүүн оруулсан нь тэр хогийн компани сонгодог больё гээд. Ерөөсөө энэ хувийн хэвшил рүү л шилжүүлэх хэрэгтэй хогийг. Тэгээд тэр хувийн хэвшил нь аваад, хогоо ангилаад, өөрсдөө мөнгө болгоод, тэгээд өрсөлдөөнтэй болгох ийм байгаа юм. Тэгэхгүй бол энэ дээр ямар нэгэн өрсөлдөөнгүй ийм юм үүсэж байна. Хөдөө орон нутгаар орон нутгийн маш их татаас явж байна. Энийг буулгах ганц хэлбэр чинь тэр тариф шүү дээ. Тэгэхээр энэ тариф гээд юмнуудаа ингээд орчихсон байгаа.

Хогийн би компаниудтай уулзаж байсан юм манай Байгаль орчны яаманд байхад. Тэгэхэд бүгдээрээ дэмжлэг хүсдэг. Тэгэнгүүт яаж дэмжсэн бэ гэхээр хогийн хог боловсруулах тоног, төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлсөн байхгүй юу, чөлөөлсөн. Энэ яах вэ нэг багахан л дэмжлэг болж байгаа. Одоо энэ нэг НӨАТ чинь нэг шинэ юм орж ирэх гээд байна шүү дээ, тэгвэл НӨАТ-аас чөлөөлдөг болчихвол бас их том дэмжлэг болох болов уу.

Дээрээс нь энэ түрүүн Мөнхсоёл хэлсэн. Тэр кока колагийнх өөрсдөө нэг ийм үйлдвэр байгуулсан, тэрэнд нь очсон, ерөөсөө хүчин чадал нь 20 хувьтай л байдаг юм байна. Яагаад гэхээр хүмүүс юмаа сайн ангилдаггүй, тэр ангилаад, тэр хог нь олддоггүй ч юм уу, ингээд бөөнд нь л тэр улаан чулуут дээр аваачаад хаячихдаг. Тэгэхээр бид энэ ангилдаггүй хогийг авахгүй болгох энэ юмыг эндээ оруулж өгмөөр байна. Тэгээд яах вэ бусдаар бол бүгд саналаа оруулсан, 1 санал, 2 саналаа бид дахиад нэмээд бичээд өгчихье. Мөнхсоёл дарга.../минут дуусав/

Б.Бейсен: Гишүүд үг хэлж дууслаа. Саналуудыг нь дэмжиж байна. Тэгэхдээ энэ Байгаль орчны яамныхан, хотын захиргаа, Аялал жуулчлалын яам, Боловсролын яамтай хамтарч байгаад ер нь хог ялган цуглуулах талаар сургалтыг ясли, цэцэрлэг, сургууль, айл өрх, ААН, албан байгууллагад сургалтыг нь сайн хийхгүй бол одоо ч хотын бүх хог хаягдал сая Одонтуяа гишүүний ярьдгаар ялгахгүй хаяж байна шүү дээ. Өдөр нь хэдэн тонноор ачдаг, хогийн цэг дээр асгадаг, энэ хог дотор төмрийн хаягдал, пластмасс, шприцийн хаягдал, цаас, картон цаасны хаягдал, шилний хаягдал, даавуу, яс гээд ингээд явж байгаа. Эд нарын зарим нь дахин боловсруулах үйлдвэрийн түүхий эд болдог байхгүй юу. Манайд шприцийн үйлдвэр гэхэд гаднаас авч байна уу түүхий эдээ сайн мэдэхгүй байна. Эмнэлгүүд дээр хуучин дотор талыг нь сайн угааж, дараа нь цуглуулдаг байсан.

Сая тээвэрлэлтийн зардлыг Бат-Эрдэнэ гишүүн хэлж байна. Энэнтэй холбоотой, тэгээд хогийн цэг дээр ачиж очих тээвэрлэлтийн үнэ дийлэхгүй болохоор чинь. Тэгэхээр энэ асуудал дээр аймгууд дээр хогийн асуудал дээр сая Одонтуяа гишүүний Хөвсгөлийн туршлага байж байна. Энийг хэрэгжүүлээд, дахин боловсруулах үйлдвэрүүд дээр энэ хог ялгах асуудлыг ялгаж байгаад, дахин боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах асуудал дээр анхаарч ажиллаад, тогтоолын төсөлдөө тусгачихсан нь зөв байх гэсэн санал хэлье. Гишүүд үг хэлж дууслаа. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

16.40 цаг

Дараагийн асуудалд оръё. Хог хаягдлын эрх зүйн орчныг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг бэлтгэсэн байна. Үүнийг хэлэлцье. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан хүрэлцэн ирсэн ажлын хэсэг хэвээрээ байгаа. Тогтоолын төслийн танилцуулгыг Ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл танилцуулна. Мөнхсоёл гишүүнд микрофон өгье.

Б.Мөнхсоёл: Тогтоолын төсөл танилцуулахаас өмнө ийм санал гаргая гэж бодож байна. 1 долоо хоногийн завсарлага хойшлуулаад, дахин боловсруулаад оруулж ирье. Энд ирсэн гишүүд оруулахуйц, манай гишүүд маань өмнө нь хийсэн ажлуудтай танилцах хугацаа ч хэрэгтэй байна гэж бодож байна. Саналуудыг нь ч бас нэмээд оруулъя. Тухайлбал энд 10 дугаар заалт дээр Аюултай хог хаягдлын жагсаалтыг шинэчлэх, бүртгэх, хяналтын нэгдсэн тогтолцоог бий болгох, аюултай хог хаягдлын нөлөөлөлд өртөх эрсдэлтэй хүн амын дунд судалгаа, шинжилгээ хийх гээд чиглэл орчихсон байхгүй юу. Түүн дээр жишээлбэл манай Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа тэр уул уурхай, эрүүл мэндийн аюултай хог хаягдал энэ тэр гээд уг нь бид нэгтгээд оруулчихсан юм. Тэгэхдээ энийг задалж, ер нь детальчлах хэрэгцээ байх юм байна гэж анзаарлаа. Товчхон оруулснаас илүү дэлгэрэнгүй оруулсан нь дээр юм шиг санагдлаа. Тэгэхээр долоо хоногийн хугацаагаар бүгдээрээ хойшлуулаад, дараагийн долоо хоногт дахиж хэлэлцээд, баталъя гэсэн ийм саналыг оруулж байна. Ажлын хэсгийнхэндээ болон гишүүддээ баярлалаа саналаа хуваалцсанд.

Б.Бейсен: Ажлын хэсгээс, Бат-Эрдэнэ гишүүн энэ асуудлаар санал хэлье гэж байна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Мөнхсоёл гишүүнд баярлалаа. Тэгээд хэдүүлээ энэ хог хаанаас үүсээд, хаана дуусах ёстой вэ гэдэг гинжин урвалыг л хөөмөөр байгаа юм манай Байгаль орчны яамныхан. Тэгээд энэ тогтоолын төсөл нь өөрөө яг тэрэнтэй холбогдоод, гинжин урвалаараа эцэслэгдэх хүртлээ л гарчихмаар байгаа байхгүй юу. Тэгэхгүй болохоор одоо тогтоолын төслөө харахаар нөгөө энд, тэнд алаг цоог, зарим нь айл өрх рүү жижигхэн асуудал, жижигхэн мэт оруулчихсан, нөгөөдөх нь гэхэд л нөгөө талдаа том асуудлууд нь хаягдчихсан ч юм шиг ингээд. Гэтэл нийт үүсэж байгаа хог хаягдал нь яах вэ, ангилал яах вэ гээд маш олон юмнууд байгаа.

Манайх бүсчлэлээс улбаатай ялангуяа маш олон хог хаягдлын цэг дээр хаягдаж байгаа бараа, бүтээгдэхүүн гэдэг юм уу, зөвхөн сав баглаа боодол биш байхгүй юу. Хөвсгөл аймгийн Жаргалант суман дээр жишээлбэл хогийн цэгийнх нь 60 хувь нь модны үртэс шүү дээ 60 хувь нь гэх мэтчилнээс авхуулаад ингээд

хөөчихмөөр байгаа юм хэдүүлээ. Тэгээд би долоо хоногийн хугацаанд Мөнхсоёл гишүүнтэйгээ хамтарч ажиллаад, ажлын хэсэгт байхгүй ч гэсэн туслаад, хэдүүлээ ингээд хөөгөөд, хөөгөөд, түүн дээр Байгаль орчны яамныхан, холбогдох ажлын хэсгийнхэн сайн туслаад, дэмжээд өгөөсэй гэж хүсэж байгаа юм. Баярлалаа.

Б.Бейсен: Ажлын хэсгийн ахлагч долоо хоногоор тогтоолын төслийг хэлэлцэхийг хойшлуулъя гэсэн саналын дагуу долоо хоногоор хойшлууллаа тогтоолын төслийг.

16.43 цаг

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Цаглавар батлах тухай/

3 дахь асуудалд орёе. Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард БОХХАА-н Байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын дарга 2026 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоох тухай 179 дүгээр захирамжийг баталсан. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд энэ дарааллыг үндэслэн хэлэлцэх асуудлын цаглаварыг Байнгын хороо баталж, мөрдүүлнэ гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард БОХХАА-н байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тогтоолын төслийг та бүхэнд хүргүүлсэн байгаа.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан саналтай гишүүд байна уу? Саналтай гишүүд байхгүй байна. Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы 5 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлдье. Гишүүд санал хураалтад бэлдсэн бол санал хураалт явуулъя. Тогтоолын төсөл 64,7 хувиар дэмжигдлээ.

16.45 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Байнгын хорооны гишүүд, ажлын хэсгийнхэнд баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА